

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ХӨГЖЛИЙН ЦОГЦ БОДЛОГО

(2008 – 2021 он)

**Алтай хот,
2008 он.**

ГАРЧИГ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛАЛ	3
ОРШИЛ.....	4
НЭГ. ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ХӨГЖЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ХӨГЖЛИЙН ДАВУУ БОЛОН СУЛ ТАЛУУД.....	5
1.1. Говь-Алтай аймгийн хөгжлийн өнөөгийн байдал	5
1.2. Говь-Алтай аймгийн хөгжлийн давуу болон сул талууд.....	5
ХОЁР. ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ХӨГЖЛИЙН АЛСЫН ХАРАА, ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛҮҮД	6
2.1. Говь-Алтай аймгийн хөгжлийн алсын хараа	6
2.2. Говь-Алтай аймгийн хөгжлийн тэргүүлэх чиглэлүүд.....	7
ГУРАВ. ХҮНИЙ ХИЙГЭЭД НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО.....	7
3.1. Ядуурал, ажилгүйдлийг бууруулах бодлого	7
3.2. Хүн ам зүйн бодлого	10
3.3. Боловсрол, соёлын хөгжлийн бодлого	12
3.4. Эрүүл мэндийн хөгжлийн бодлого.....	15
ДӨРӨВ. ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО	18
4.1. Макро эдийн засгийн бодлого.....	18
4.2. Эдийн засгийн бодит салбаруудын хөгжлийн бодлого	20
4.2.1. Аж үйлдвэрийн хөгжлийн бодлого	20
4.2.2. Хөдөө аж ахуйн хөгжлийн бодлого	24
4.2.3. Аялал жуулчлалын салбарын хөгжлийн бодлого	28
4.3. Дэд бүтцийн хөгжлийн бодлого	31
4.3.1. Зам, тээврийн хөгжлийн бодлого.....	31
4.3.2. Эрчим хүчний салбарын хөгжлийн бодлого	32
4.3.3. Мэдээлэл, харилцаа холбооны салбарын хөгжлийн бодлого	34
4.4. Хот байгуулалт, барилгын салбарын хөгжлийн бодлого	36
ТАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ БОДЛОГО	38
ЗУРГАА. ХҮРЭХ ГОЛ ҮР ДҮН, ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ МЕХАНИЗМ	44
6.1. Цогц бодлогыг хэрэгжүүлснээр хүрэх гол үр дүн	44
6.2. Цогц бодлогын хэрэгжилтийг хангах механизм	45

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛАЛ

УИХ	Улсын Их Хурал
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
МСҮТ	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв
МАА	Мал аж ахуй
ТХГН	Тусгай хамгаалалттай газар нутаг
ХАА	Хөдөө аж ахуй
УЦС	Усан цахилгаан станц
ХДХВ	Хүний дархлал хомсдолын вирус
БЗХӨ	Бэлгийн замын халдварт өвчин
ДОХ	Дархлалын олдмол хомсдол

ОРШИЛ

1. Говь-Алтай аймгийн хөгжлийн цогц бодлого (2008-2021 он)-ыг Монгол Улсын Ерөнхийлөгч Намбарын Энхбаяр санаачилж, манай орны эрдэмтэд, улс төрчид, иргэдийн өргөн оролцоотойгоор боловсруулж, УИХ-ын 2008 оны 12 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилгод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого (2007-2021 он)”-д тулгуурлан боловсруулав.

2. “Говь-Алтай аймгийн хөгжлийн цогц бодлого (2008-2021он)”-д “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”, “Бүсүүдийн хөгжлийн дунд хугацааны стратеги (2010 он хүртэл)”, “Монгол Улсын Баруун бүсийн хөгжлийн хөтөлбөр(2015 он хүртэл)” болон Монгол Улсын хөгжлийн бодлогын бусад баримт бичгүүдийн үзэл санаа, хэрэгжилтийн явц, үр дүн, залгамж чанар тусгалаа олсон болно.

3. “Говь-Алтай аймгийн хөгжлийн цогц бодлого (2008-2021он)”-д “Аймгийг хөгжүүлэх төсөл”, “Говь-Алтай аймгийн XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр”, “Говь-Алтай аймагт барилгын салбарыг 2020 он хүртэл хөгжүүлэх мастер төлөвлөгөө”, “Говь-Алтай аймгийн мэдээлэл, холбооны салбарыг хөгжүүлэх хөтөлбөр /2008-2015 он/”, “Говь-Алтай аймагт байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх талаар 2010 он хүртэл хэрэгжүүлэх мастер төлөвлөгөө”, “Аймгийн Мал аж ахуйг эрчимжүүлэн хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр /2005-2015 он/”, “Ногоон хувьсгал дэд хөтөлбөр”, “Газар тариаланг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр /2008-2012 он/”, “Атрын гурав дахь аян (газар тариалангийн хөгжлийн дэд хөтөлбөр)/2008-2010 он/”, “Аймгийн боловсролын салбарыг хөгжүүлэх мастер төлөвлөгөө /2008-2015 он/”, “Говь-Алтай аймгийн онцлогт нийцсэн Мянганы хөгжлийн зорилтууд /2008-2015 он/” зэрэг аймгийн хэмжээний хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн үзэл санаа, хэрэгжилтийн явц, үр дүн, залгамж чанар мөн тусгалаа олсон болно.

4. Говь-Алтай аймгийн урт хугацааны хөгжлийн стратегийн зорилтууд, хүрэх үр дүнг 2008-2015 он, 2016-2021 он гэсэн үндсэн хоёр үе шатаар тусгав.

НЭГ. ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ХӨГЖЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ХӨГЖЛИЙН ДАВУУ БОЛОН СУЛ ТАЛУУД

1.1. Говь-Алтай аймгийн хөгжлийн өнөөгийн байдал

Говь-Алтай аймагт 2007 оны байдлаар манай улсын нийт хүн амын 2.3 хувь, Баруун бүсийн хүн амын 15 орчим хувь буюу 57.8 мянган хүн оршин сууж байна. Аймгийн нийт хүн амын 28,7 хувь буюу 3694 өрхийн 16599 хүн амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой, өөрөөр хэлбэл ядуу амьдарч байна. Боловсрол, эрүүл мэнд зэрэг нийгэм(социаль)-ийн салбаруудын хүрээнд шийдвэрлэвэл зохих олон асуудал хуримтлагдсан байна.

Говь-Алтай аймгийн эдийн засгийн хөгжлийн түвшин харьцангуй доогуур байна. Нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 961.0 мян.төгрөг байгаа нь улсын дунджаас 1.8 дахин бага байна. Аймгийн эдийн засгийн салбарын бүтэц ч ихээхэн хоцрогдсон байна. Тухайлбал, 2007 оны байдлаар аймгийн ДНБ-ий үйлдвэрлэлд бэлчээрийн МАА-д суурилсан хөдөө аж ахуйн салбар 67.8 хувь, аж үйлдвэр, барилгын салбар 7.6 хувь, үйлчилгээний салбар 24.6 хувийг тус тус эзэлж байна. Мөн боловсруулах үйлдвэрлэл, дэд бүтэц нэн сул хөгжсөн. Говь-Алтай аймаг 2007 оны байдлаар төсвийн зарлагынхаа 60.7 хувийг улсаас олгож буй татаасаар бүрдүүлж байна.

Байгалийн нөөцийн ашиглалт, хамгааллын холбогдолтой шийдвэрлэвэл зохих асуудлууд ч цөөнгүй байна. Говь-Алтай аймаг Монгол Улсын цөлжилтөд ихээхэн өртсөн аймгуудын нэг юм. Сүүлийн жилүүдэд малын тоо толгой өссөний зэрэгцээ сүргийн бүтэц алдагдсантай холбоотойгоор нийт нутгийн хэмжээгээр бэлчээрийн даац хүрэлцэхгүй байдал ажиглагдаж байна. Мөн худаг, ус тойрсон бага хэмжээний газар олон тооны мал бөөгнөрч бэлчээрийн талхагдлыг ихэсгэж байна. Дэлхийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон чадавхийг бий болгож, цөлжилтийг сааруулж, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах нь томоохон тулгамдсан асуудал болоод байна.

1.2. Говь-Алтай аймгийн хөгжлийн давуу болон сул талууд

Говь-Алтай аймгийг 2008-2021 он хүртэл хөгжүүлэх цогц бодлогод хөгжлийн дор дурдсан давуу болон сул талуудыг тооцон үзэв.

Үүнд:

Хөгжлийн давуу талууд:

- Хүн амын бичиг үсэг тайлагдалтын түвшин өндөр;
- Боловсруулах аж үйлдвэрийг хөгжүүлж экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэн дэлхийн зах зээлд өрсөлдөхөд ашиглаж болох МAA-н түүхий эдийн арвин нөөцтэй ;
- Эрдэс баялгийн нөөцөө ашиглаж уул уурхай, барилгын материалын үйлдвэрүүдийг байгуулан хөгжүүлэх боломжтой;
- БНХАУ-ын томоохон зах зээлд ойр дөт ;
- Байгалийн аялал жуулчлалыг хөгжүүлэх өргөн боломжтой зэрэг болно.

Хөгжлийн сул талууд:

- Хүн амын тоо цөөн, өсөлт удаан, тархай бутархай байршилтай, ажилгүйдэл ядуурлын түвшин өндөр;
- Хөдөлмөрийн нөөц хязгаарлагдмал, ур чадвартай инженер техникийн ажилтан, ажилчид, зах зээлийн мэдлэгтэй мэргэжилтний тоо цөөн;
- Боловсрол, эрүүл мэндийн салбарын хөгжлийн түвшин доогуур , энэ талын тулгамдсан асуудлууд хуримтлагдсан;
- Эдийн засгийн салбарын бүтэц ихээхэн хоцрогдсон, эдийн засагт бэлчээрийн МAA-д суурилсан хөдөө аж ахуйн салбар голлох үүрэгтэй;
- МAA, газар тариалангийн үйлдвэрлэл байгаль, цаг агаарын байдлаас хэт хамааралтай;
- Зам харилцаа, эрчим хүчний дэд бүтэц сул хөгжсөн;
- Аймгийн дотоод зах зээлийн багтаамж бага, Монгол Улсын нийслэл хотын болон Төвийн бүсийн томоохон зах зээлээс алслагдсан;
- Дэлхийн уур амьсгалын өөрчлөлт болон хүний сөрөг үйл ажиллагааны нөлөөгөөр цөлжилтийн үйл явц хурдассан зэрэг болно.

ХОЁР. ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ХӨГЖЛИЙН АЛСЫН ХАРАА, ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛҮҮД

2.1. Говь-Алтай аймгийн хөгжлийн алсын хараа

Говь-Алтай аймгийн хөгжлийн 2021 он хүртэлх алсын хараа нь хүний хөгжилд тулгуурлан эдийн засгийг эрчимтэй хөгжүүлж хүн амын амьдралын түвшинг тууштай дээшлүүлэн, Мянганы хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлж, Монгол Улсын өөрөө өөрийгөө тэтгэдэг, оновчтой бүтэцтэй,

мэдлэгт суурилсан эдийн засагтай, цэцэглэн хөгжиж буй аймаг болоход оршино.

2.2. Говь-Алтай аймгийн хөгжлийн тэргүүлэх чиглэлүүд

Говь-Алтай аймгийн хөгжлийн цогц бодлогыг дараах таван тэргүүлэх чиглэлийн хүрээнд хэрэгжүүлнэ:

- 1) Аймагт мянганы хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлж, хүнийг бүх талаар хөгжүүлнэ.
- 2) Дэлхийн болон дотоодын зах зээлд өрсөлдөх чадвартай, хувийн хэвшилд тулгуурласан экспортын баримжаатай үйлдвэрлэл, үйлчилгээг эрчимтэй хөгжүүлж, аймгийн эдийн засгийг олон талтай, мэдлэгт суурилсан болгоно.
- 3) Зам тээвэр, эрчим хүч, мэдээлэл холбооны дэд бүтцийг эрчимтэй хөгжүүлж хөгжлийн таатай орчин бүрдүүлнэ.
- 4) Аймгийн төв, сумдын төвүүдийг хөгжүүлж хот, хөдөөгийн хөгжлийн түвшний ялгааг багасгана.
- 5) Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон чадавхийг бий болгон цөлжилтийг сааруулж, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгална.

ГУРАВ. ХҮНИЙ ХИЙГЭЭД НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Говь-Алтай аймгийн хөгжлийн 1 дэх тэргүүлэх чиглэлийг хэрэгжүүлнэ. Аймагт ядуурал, ажилгүйдлийг тууштай бууруулж, иргэн бүрийн амьдралын чанарыг тасралтгүй дээшлүүлнэ. Гэр бүлийг хөгжүүлж, хүн ам зүйн оновчтой бодлогыг хэрэгжүүлнэ. Хүн амын боловсрол, соёл, эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийг эрс сайжруулна. 2015 он гэхэд мянганы хөгжлийн зорилтуудыг бүрэн хэрэгжүүлнэ.

3.1. Ядуурал, ажилгүйдлийг бууруулах бодлого

Үндэслэл: Аймгийн нийт хүн амын 28,7 хувь буюу 3694 өрхийн 16599 хүн амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой, ядуу амьдарч байна. Амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой иргэдийн тоо 1994 онд аймгийн нийт хүн амын 22,7 хувь байсан бол 2007 онд 28,7 хувь болон нэмэгдсэн байна. Ажилгүйдэл, ядуурлыг бууруулахад чиглэсэн олон

арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа боловч ядуурал дорвитой буурахгүй байна. Ядуу өрхийн дийлэнх олонхи нь аймгийн төвд болон сумдын төвд амьдарч байна. Ажилгүйдлийн түвшин улсын дунджаас өндөр байна. Ажилгүйдлийг дагалдан ядуурал өсч байна.

Нэгдүгээр үе шат (2008-2015 он):

Стратегийн зорилт 1. Аймгийн хэмжээнд мянганы хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлж ядуурлыг 2 дахин бууруулна.

- Говь-Алтай аймгийн хөгжлийн энэхүү цогц бодлоготой нягт уялдуулан “Эдийн засгийн өсөлтийг дэмжих, ядуурлыг бууруулах дунд хугацааны хөтөлбөр” боловсруулан хэрэгжүүлэх;
- Эдийн засгийн өсөлт, хөрөнгө оруулалтын арга хэмжээтэй уялдуулан ажлын байрыг тууштай нэмэгдүүлж, ажилгүйдлийн түвшинг 2.0 хувиас дээшгүй байлгах;
- Ажлын байр шинээр бий болгосон аж ахуйн нэгж, байгууллагад эдийн засгийн урамшуулал олгох;
- Ажилгүй, ядуу, нэн ядуу иргэдэд мэргэжил, ажлын дадлага туршлага эзэмшүүлэх, хөгжлийн зээл, тусламжид хамруулах зэргээр дэмжлэг үзүүлэх;
- Ядуу, бага орлоготой малчин залуусыг уламжлалт мал маллагааны арга барилд сургах;
- Ядуу өрхийг нөхөрлөл, хоршоололд хамруулан, аж ахуй эрхлэхэд нь санхүүгийн дэмжлэг үзүүлэх;
- Байгаль орчныг хамгаалах, ялангуяа цөлжилттэй тэмцэх, ойн зурвас байгуулах, хөрс, бэлчээрийг хамгаалах зэрэг ажилд хөдөлмөр эрхлээгүй иргэдийг өргөн оролцуулах;
- Ядуурлыг бууруулах зорилгоор хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөрүүдийн үйл ажиллгааг орон нутагт идэвхижүүлж, уялдаа холбоог нь сайжруулах;
- Хөдөлмөр эрхлэлтийн сан болон бусад хөтөлбөр, төслүүдийн хүрээнд хугацааны хувьд байнгын, үнэлгээний хувьд цалин өндөртэй ажлын байрыг бий болгох;
- Жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ, дэд бүтэц, аялал жуучлалын салбарт хөдөлмөр эрхлэлтийг тууштай дэмжих;

- Хөдөлмөрийн зах зээлд шаардлагатай мэргэжлийн сургалтыг өргөтгөх хөтөлбөрийг хувийн хэвшлийнхэнтэй хамтран хэрэгжүүлэх;

Стратегийн зорилт 2. Нийгмийн халамжийн үйлчилгээний хүртээмж, чанарыг эрс сайжруулж, эмзэг бүлгийн иргэдийн нийгмийн хамгааллын тогтолцоог боловсронгуй болгоно:

- Аймгийн төв, сумын төвүүдийн түвшинд нийгмийн халамжийн бүх төрлийн үйлчилгээг эрс сайжруулах;
- Нийгмийн даатгалд хамрагдах хүрээг нэмэгдүүлж, тэтгэврийн суурь даатгалын тогтолцоонд аймгийн хүн амыг бүрэн хамруулах;
- “Тогтвортой амьжиргааг дэмжих” төслийн хүрээнд ядуу, эмзэг бүлгийн иргэдэд туслах;
- Бүтэн өнчин, тэнэмэл, нэн ядуу өрхийн хүүхдүүдэд туслах халамжийн төвүүдийг байгуулж ажиллуулах;
- Ядуу иргэд, орон гэргүй хүмүүс гэр, хашаа, орон сууц худалдан авах, барих, орон байраа өргөтгөх, засварлах зориулалт бүхий орон сууцны зээлийн үйлчилгээг нэмэгдүүлэх;
- Хүн амын эмзэг бүлгийг дэмжих зорилгоор “Өрхийн хөгжлийн төлөвлөгөө”-г өөрсдийн нь оролцоотой боловсруулан хэрэгжүүлэх;
- Хөдөлмөр эрхлээгүй хүмүүс, ялангуяа нийгмийн эмзэг бүлгийн иргэдийг дэд бүтцийн томоохон бүтээн байгуулалт, суурин газрын нийтийн эзэмшлийн зам талбай, ногоон байгууламжийн тохижилт, үйлчилгээний ажилд оролцуулах;
- Ахмад настны амралт сувилалын газар, чийрэгжүүлэлтийн танхим нээн ажиллуулах, тэдэнд үзүүлж байгаа тусламж, хөнгөлөлтийг боловсронгуй болгох;
- Байнгын ажиллагаатай хүүхдийн хөгжлийн төвийг байгуулж ажиллуулах;
- Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг зөвөлгөө өгөх төвийг байгуулж ажиллуулах;
- Аймагт ажиллаж амьдарч байгаа төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчдын цалинг бүсийн ялгавартай нэмэгдүүлэн тогтоох саналыг боловсруулж шийдвэр гаргуулах;

Хоёрдугаар үе шат (2016-2021 он):

Стратегийн зорилт 1. Ядуурлыг бууруулахад бүхий л хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн оролцоог сайжруулна:

- Амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой иргэдийн тоог 2015 оны түвшингээс хоёр дахин бууруулах;
- Ядуурлыг бууруулах, өрхийн амьжиргааг дээшлүүлэхэд чиглэсэн томоохон төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх;
- Амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг бүх талаар дэмжих;

Стратегийн зорилт 2. Нэн ядуу иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд чиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээг боловсронгуй болгоно:

- Бүтэн өнчин, тэнэмэл болон нэн ядуу өрхийн хүүхдийн халамж үйлчилгээний төвүүдийг шинээр байгуулж, амьдралын арга ухааныг зааж сургах;
- “Нийгмийн халамжийн сан”-гийн үйл ажиллагааны үр өгөөжийг нэмэгдүүлэх;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх дэмжлэг, үйлчилгээний хүрээ, хүртээмжийг тэдний амьдралын чанар, онцлогийг харгалзан нэмэгдүүлэх;
- Ахмад настанд үзүүлдэг тусламж, хөнгөлөлтийг сайжруулах;

3.2. Хүн ам зүйн бодлого

Үндэслэл: Хүн амын тоо цөөн, өсөлт удаан байна. Хүн амын дундаж наслалт улсын хэмжээнд 65.9 байхад Говь-Алтай аймагт 63.9 байна. Хүний хөгжлийн индексийн улсын дундаж 0.718 байхад Говь-Алтай аймагт 0.679 байна. Цаашид гэр бүлийн гүйцэтгэх үүргийг дээшлүүлэн хүүхэд эрүүл аюулгүй орчинд өсөж, сурч боловсрох таатай орчин бүрдүүлэх шаардлагатай байна.

Нэгдүгээр үе шат (2008-2015 он):

Стратегийн зорилт 1. Хүн амын жилийн дундаж өсөлтийг тууштай нэмэгдүүлнэ:

- Аймагт “Гэр бүл, хүүхдийн цогц хөгжил” дэд хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх;
- Аймаг, сумдын хөгжлийн бодлого, төлөвлөлтөд хүн амын хүчин зүйлсийг оновчтой тусган хэрэгжүүлэх;

- Залуу гэр бүл, шинээр төрсөн хүүхдийг дэмжих сан байгуулж ажиллуулах;
- Хүн амын эмзэг бүлгийн хөгжлийг дэмжих хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх;
- Өрх бүрээр ургийн бичиг хөтлүүлж занших;
- Хүн амын дундаж наслалтыг улсын дундажад хүргэх;

Стратегийн зорилт 2. Хүнийг бүх талаар хөгжүүлэн, аймгийн хэмжээнд хүний хөгжлийн индексийн дундаж үзүүлэлтийг 0.700-аас бууруулахгүй байна:

- Аймгийн төв, сумдын түвшинд бүх шатны сургалтын материаллаг баазыг бэхжүүлэн, сургалтын чанарыг сайжруулах;
- Эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийг тууштай сайжруулах;
 - Бичиг үсэг үл мэдэх явдал, сургууль завсардалтыг эрс багасгах;
 - “Өсвөр үе, залуучуудын хөгжлийг дэмжих Үндэсний хөтөлбөр”, “Жендэрийн тэгш байдлыг хангах Үндэсний хөтөлбөр”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих Үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх;
- Аймгийн эдийн засгийн өсөлтийг хурдасгаж, салбарын бүтцийг шинэчлэх бодлоготой уялдуулан хүн амын орлогыг тасралтгүй нэмэгдүүлэх;
 - Бизнесийн байгууллагуудын ажилтнуудад гадаад худалдааны гэрээ хэлцэл хийх ур чадвар эзэмшүүлэх, маркетинг, менежмент, эдийн засаг, худалдааны мэдлэг олгох;

Хоёрдугаар үе шат (2016-2021он):

Стратегийн зорилт 1. Хүн амын жилийн дундаж өсөлтийг улсын дундаж түвшинд хүргэнэ:

- Аймгийн эдийн засгийн өсөлтийг түргэсгэн ажлын байрны хангамжийг сайжруулах замаар гадагш чиглэсэн шилжилт хөдөлгөөнийг зохистой түвшинд байлгах;
- Төрөлтийг дэмжих зорилгоор өрхийн орлогод ногдох албан татварт хөнгөлөлт үзүүлэх, өрхийн хүүхдийн тоо, насны ялгааг харгалзан тэтгэлэг олгох зэрэг арга хэмжээг өргөтгөх;

Стратегийн зорилт 2. Хүнийг хөгжүүлэх боломжийг бүрэн ашиглах замаар аймгийн хэмжээнд хүний хөгжлийн индексийн дундаж үзүүлэлтийг 0.720-аас бууруулахгүй байна:

- Аймаг, сумдын түвшинд хүн амын орлогыг нэмэгдүүлэх, боловсролын түвшинг дээшлүүлэх, эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах арга хэмжээг тууштай үргэлжлүүлэх;
- Боловсролын тогтолцоог боловсронгуй болгож, бүх шатны боловсролын хүртээмжийг сайжруулах;
- Эдийн засгийн өсөлт, салбарын бүтцийн өөрчлөлттэй уялдуулж мэргэжилтэй ажилтан бэлтгэх тогтолцоог боловсронгуй болгох;

3.3. Боловсрол, соёлын хөгжлийн бодлого

Үндэслэл: Аймагт суурь боловсролын хамран сургалт 92.7 хувьтай, сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт 52,3 хувьтай байна. Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв болон Анагаах Ухааны Коллежид мэргэжлийн боловсрол олгож байна. Гэвч сургууль завсардалт, бичиг үсэг үл мэдэх явдал арилаагүй байна. Цаашид нийгэм-эдийн засгийн эрчимтэй хөгжлийн эрэлт шаардлагад нийцсэн оюунжсан бүтээлч, чадамжтай хүний нөөцийг бий болгох чиглэлээр бүх нийтийн боловсролын тогтолцоог хөгжүүлэх шаардлагатай байна.

Нэгдүгээр үе шат (2008-2015 он):

Стратегийн зорилт 1. Суралцагчидад хүртээмжтэй, чанартай, хэрэгцээнд нь нийцсэн боловсрол эзэмшүүлнэ:

- Ерөнхий боловсролын сургуулиудын байршил, хэв шинжийг орон нутгийн засаг захиргааны нэгжийн онцлогтой уялдуулан оновчтой тогтоох;
- Сум бүрт сургуулийн өмнөх боловсролыг гэрийн нөхцөлд ойртуулах арга хэмжээ авч, хүүхдийн цэцэрлэгийн хамран сургалтыг эрс нэмэгдүүлэх;
- Зургаан настай хүүхдийг бага боловсролд бүрэн хамруулах;
- ЕБС-д суралцагчдын хүйсийн тэгш бус байдлыг арилгах;
- Бүх шатанд монгол хэл, бичгийн сургалтыг чанаржуулж, эх хэлээ төгс эзэмших хөдөлгөөнийг урамшуулан дэмжих;
- Англи хэлийг бүх нийтийн голлох гадаад хэл болгох;
- Дунд сургуулиудад гадаад хэл, байгаль, техникийн ухааны чиглэлээр гүнзгийрүүлсэн сургалттай анги нээн ажиллуулах;
- Малчдыг зайны сургалтад хамруулах оновчтой арга, хэлбэрийг сонгон нэвтрүүлэх;

- Малчдын хүүхдийг сургуульд бүрэн хамруулж, чанартай бэлтгэх зорилгоор явуулын багштай нүүдлийн сургууль болон гэр цэцэрлэг ажиллуулах;
- ЕБС-ийн дотуур байрны хүчин чадлыг 2 дахин нэмэгдүүлэх;
- Гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татах замаар аймгийн төвийн МСҮТ-ийг бэхжүүлэн аймгийн болон баруун бүсийн хэрэгцээг хангахуйц нарийн мэргэшсэн мэргэжилтэй ажилчдыг бэлтгэх;
- ХАА-н мэргэжилтэн бэлтгэх МСҮТ-ийг зарим суманд байгуулан ажиллуулахыг дэмжих;
- Физик, одон орон, газар зүй, хими биологи зэрэг байгалийн ухааны хичээлийн кабинетыг орчин үеийн лабораторийн багаж хэрэгсэл, бодисоор хангах, физик, химийн лаборант бэлтгэх;
- Уул уурхай, барилга, мэдээлэл-технологийн чиглэлээр дунд, дээд боловсролтой мэргэжилтэн бэлтгэх сургууль байгуулж ажиллуулах;
- Авъяастай, амжилттай суралцахаа харуулсан 10 хүртэл тооны залууг уул уурхай, биотехнологи, мэдээллийн технологийн чиглэлээр жил бүр сонгон шалгаруулж, өндөр хөгжилтэй орнуудад төрийн зардлаар сургах;
- Их, дээд сургуультай хоршсон шинжилгээ судалгааны төрөлжсөн салбар, мэдээллийн технологийн төвүүд байгуулж ажиллуулахыг урамшуулан дэмжих;
- Өндөр мэргэшилтэй багш нар, соёлын төвийн ажилтнуудыг орон нутаг ажиллуулах эдийн засгийн урамшууллын шинэ хөшүүрэг бий болгох;

Стратегийн зорилт 2. Албан бус боловсролын үйлчилгээний хүртээмж, чанар, үр ашгийг дээшлүүлэх:

- Албан бус боловсрол олгох хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх;
- Албан бус боловсролын тогтолцоонд ажиллах орон тооны болон орон тооны бус багш бэлтгэх;

Стартегийн зорилт 3. Бүх шатны сургуулиудын материаллаг баазыг бэхжүүлэн, менежментийг нь сайжруулна:

- Бага сургууль, цэцэрлэгийн тоглоом, наадгай, сургалтын хэрэглэгдэхүүний хангамжийг сайжруулах;
- Сургууль, цэцэрлэгүүдийн гал тогооны тоног төхөөрөмжийг иж бүрэн шинэчлэн эрүүл ахуйн стандартад бүрэн нийцүүлэх;

- Дотуур байрны болон цэцэрлэгийн хүүхдийн хоолны төрөл, амт, чанарыг сайжруулж илчлэгийг стандартын хэмжээнд байлгах;
- Сургууль бүрийг хямд өртөгтэй, найдвартай ажиллагаа бүхий интернет номын сантай болгож, хүүхэд бүрт компьютер хөтөлбөрийг хэрэгжүүлэх;
- Боловсрол соёлын салбар дахь хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг бүхий л талаар дэмжих, урамшуулах,
- Гадаад орны мэргэжлийн төрөлжсөн байгууллагууд, хандивлагчдаас боловсролын салбарын материаллаг баазыг бэхжүүлэх чиглэлээр төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхийг бүх талаар дэмжих;
- Боловсрол, соёлын байгууллагын удирдлагын чадавхийг дээшлүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах нөхцлийг бүрдүүлэх;
- Сургууль, соёлын ажилтнуудыг орон сууцны хөтөлбөрт хамруулах, хувиараа орон сууц барихыг дэмжих;
- Өндөр зэрэглэлийн эрдэмтэн багш нар болон үндэсний тэргүүлэх мэргэжилтэн нар орон нутагт ирж ажиллах санаачлагыг онцгойлон дэмжих;
- Сумдын ЕБС-ийн хичээлийн байр, дотуур байр, цэцэрлэгийн байрыг засварлах, тохижуулах, шинээр барих;

Стратегийн зорилт 4. Урлаг, соёлын байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгож, үйлчилгээний чанар, хүртээмжийг нь сайжруулна:

- Суманд соёлын төв, зарим суманд урлаг-соёл-спортын төв, аймгийн төвд мэргэжлийн урлаг-соёлын хосолсон үйлчилгээтэй байгууллагуудыг ажиллуулж соёлын үйлчилгээг сайжруулна.
- Угсаатны зүй, үндэстэн ястны соёлыг дэмжих төвийг аймгийн төвд ажиллуулах;
- Сумдын номын сан, музей, соёлын төвүүдийн байрны хангамж, материаллаг баазыг бэхжүүлэн үйлчилгээг өргөжүүлж, хүн амд мэдээлэл хүргэх төв болгон ажиллуулах;
- Аймгийн номын санг “Номын өргөө” болгон зохион байгуулах;
- Аймгийн соёл урлагийн байгууллагуудын менежментийг сайжруулах;

Хоёрдугаар үе шат (2016-2021 он):

Стратегийн зорилт 1. Аймгийн боловсролын тогтолцоо, сургалтын хэв шинжийг хөгжсөн орнуудын нийтлэг жишигт хүргэнэ:

- Мэргэжлийн сургалттай ахлах сургуулиудийг ажиллуулах;
- Аймгийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн өндөр хөгжилтэй орнуудад жил бүр 20-оос доошгүй оюутныг сургаж, сургалтын зардлыг орон нутгийн болон улсын төсвөөс санхүүжүүлэх;
- Ерөнхий боловсролын сургуулиудын нийт багш нарыг хөрвөх чадвартай болгон чадваржуулах;
- Сургууль завсардалт болон бичиг үсэг үл мэдэх явдлыг бүрэн арилгах;
- Багш, боловсролын байгууллагын удирдах ажилтны ур чадварыг хөгжүүлж, нийгмийн хамгааллыг нь сайжруулах;

Стратегийн зорилт 2. Соёл урлагийн байгууллагуудын үйлчилгээний хүртээмж, чанарыг эрс дээшлүүлнэ:

- Сум дундын соёлын байгууллага бий болгох;
- Урлагийн гоц авьяастан, урчууд, уран бүтээлчдийг тодруулан авьяасыг нь төгс хөгжүүлэх хөтөлбөр, төслүүдийг хэрэгжүүлэх;
- Номын сан, архивын үйлчилгээг хүн амын эрэлт хэрэгцээнд нийцүүлэн сайжруулах;

3.4. Эрүүл мэндийн хөгжлийн бодлого

Үндэслэл: Говь-Алтай аймагт эрүүл мэндийн салбарын 30 гаруй байгууллага хүн амд үйлчилгээ үзүүлж, эмчилгээ-оношлогооны чанар, тоног төхөөрмжийн хангамж хүрэлцээ сайжирч байна. Гэвч боловсон хүчний хангамж, мэргэжлийн ур чадварын түвшин харилцан адилгүй, санхүүгийн чадавхи хязгаарлагдмал, сум, сум дундын болон өрхийн эмнэлгийн үйлчилгээний чанар, хүртээмжийн түвшин доогуур, эх нялхасын эндэгдэл, халдварт өвчний гаралт буурахгүй байна. Хорт хавдрын болон хоол боловсруулах эрхтэний өвчлөл өсч байна. Цаашид эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүн амд тэгш хүртээмжтэй, чанартай үзүүлэн өвчлөл, эндэгдлийг тууштай бууруулж, орчин үеийн дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэн эмчилгээ оношлогооны чанарыг сайжруулан, хүн ам эрүүл, урт наслах нөхцлийг бүрдүүлэх шаардлагатай байна.

Нэгдүгээр үе шат (2008-2015 он):

Стратегийн зорилт 1. Хүн амын эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулна:

- Аймгийн эрүүл мэндийн салбарын хөгжлийн мастер төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх;
- “Эрүүл Монгол Хүн” хөтөлбөрийн хүрээнд бүх нийтийг хамарсан эрүүл мэндийн үзлэг, оношлогоог бүх сум, багт зохион байгуулах;
- Аймгийн хүн амын эрүүл мэндийн байдлыг хянан тандаж мэдээлэх тогтолцоо бүрдүүлэх;
- Эрүүл хот, сум, баг болох хөдөлгөөн өрнүүлж, иргэний нийгмийн байгууллага, хувь хүн, хамт олны оролцоог эрс нэмэгдүүлэх;
- Эрүүл мэндийн салбарын шинэтгэлийг эрчимжүүлж, ДЭМБ-ын зөвлөмжинд тулгуурлан хөгжилтэй орнуудын эрүүл мэндийн бүтэц, зохион байгуулалтанд ойртуулах;
- Аймгийн нэгдсэн эмнэлгийг орчин үеийн оношлогоо, эмчилгээний техник, технологиор нарийн мэргэжлийн тусламж, үйлчилгээг хүн амд үзүүлдэг, мэргэжлийн болон ёс зүйн өндөр ур чадвар бүхий чадварлаг баг, хамт олонтой болгох;
- Сумын болон өрхийн эмнэлгийг иргэдэд, ялангуяа эх, хүүхэд, ахмадуудад болон ядуу, эмзэг бүлгийн иргэдэд эрүүл мэндийн суурь тусламж үйлчилгээг чанартай, жигд хүртээмжтэй үзүүлдэг “Эрүүл мэндийг дэмжих төв” болгон бэхжүүлэх;
- Олон улсын хөл хориот өвчнөөс аймгийн хүн амыг хамгаалахад чиглэсэн лаборатори, оношлогоо эмчилгээний явуулын багийн чадамжийг сайжруулах;
- 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл болон нялхсын эндэгдлийн түвшинг 1000 амьд төрөлт тутамд 25.8-аас цөөн болгож бууруулах;
- Улаан бурхны эсрэг вакцинжуулалтад хамрагдалтыг 99 хувьд хүргэх;
- Эхийн эндэгдлийн түвшинг 100 000 амьд төрөлт тутамд 57.1-ээс цөөн болгон бууруулах;
- Сүрьеэгийн тархалт болон өвчлөлийн түвшинг 100 000 хүн тутамд 35-аас цөөн болгон бууруулах;

- Нэгдсэн эмнэлэг, сумын эмнэлгийн түвшинд ХДХВ|ДОХ|БЗХӨ-ний харуулдан тандалтын тогтолцоог өргөжүүлж, оношлогоо, эмчилгээний хүртээмж, чанарыг эрс сайжруулах;
- Эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийг тууштай сайжруулах замаар 2015 он гэхэд хүн амын дундаж наслалтыг улсын дундаж түвшинд хүргэх нөхцлийг бүрдүүлэх;
- Нэн ядуу, эмзэг бүлгийн хүмүүс, тахир дутуу иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлэх боломжийг нэмэгдүүлэх;
- Малчдад нүүдлийн хэлбэрээр эмнэлэг, үйлчилгээний анхан шатны тусламж үзүүлэх тогтолцоог бүрдүүлэх;
- Эмнэлэгийн тусламж үйлчилгээнд алсын зайны оношлогоо, эмчилгээний аргуудыг нэвтрүүлэх;

Стратегийн зорилт 2. Эрүүл мэндийн байгууллагын материаллаг бааз, боловсон хүчний хангамжийг сайжруулна:

- Эмнэлгийн болон эхчүүдийн амрах байруудыг засварлан тохижуулах, шинээр барих;
- Эрүүл мэндийн салбарт ажиллагсдын нийгмийн баталгааг сайжруулах, урамшууллын тогтолцоог боловсронгуй болгох;
- Эмч, эмнэлгийн ажилтнуудыг орон сууцаар ээлж дараатай хангах, урт хугацааны зээлд хамруулах;
- Анагаах ухааны коллежийг өргөтгөн ерөнхий мэргэжлийн их эмч, бага эмч, сувилагчдыг гэрээгээр бэлтгэдэг Баруун бүсийн анагаах ухааны сургалтын төв болгох;
- Эмнэлгийн боловсон хүчнийг сумдын захиалгыг үндэслэн бэлтгэх;
- Сумын, сум дундын болон нэгдсэн эмнэлэгүүдийг шинэ байртай болгох, хуучин байрыг нь сэргээн засварлах, нийт сумдын эмнэлэгийн гал тогооны тоног төхөөрмжийг шинэчлэх ажлыг ээлж дараатай хэрэгжүүлэх;
- Аймгийн төвд Уламжлалт анагаах ухааны төв, Эх нялхасын төвийг шинээр байгуулж иргэдэд нарийн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх;
- Хүнхэр, Цутгалан, Гүн нуур, Цангилахын гол зэрэг байгалийн үзэсгэлэнт газар рашаануудыг түшиглэн амралт, сувиллын тохилог газруудыг байгуулах;

- Эрээн нуур, Ээж уул, Бигэрийн таван элс (Бөөрийн сувилал)-ийг түшиглэн дотоод, гадаадын хөрөнгө оруулалт бүхий улсын чанартай сувилал, амралт, байгалийн аялал жуулчлалын төв байгуулах;
- Хүн амыг хөдөлгөөний хомсдолоос урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэх, чийрэгжүүлэх төвийг аймаг, сумын төв, байгууллагуудад зохистой хэлбэрээр бий болгон хөгжүүлэх;

Хоёрдугаар үе шат (2016-2021 он):

Стратегийн зорилт 1. Эрүүл мэндийн салбарын материаллаг баазыг бэхжүүлж, удирдлага, санхүүжилтийн нэгдмэл тогтолцоог хөгжүүлнэ:

- Мэдээллийн технологийн ололт амжилтыг эмнэлгийн тусламж үйлчилгээнд бүрэн нэвтрүүлэн “Цаасгүй эмнэлэг”-ийг бий болгож, хүн бүрийг эмнэлгийн цахим карттай болгох;
- Өндөр түвшний үйлчилгээтэй хувийн эмнэлгийн байгууллагуудыг дэмжин хөгжүүлэх;
- Аймгийн төвд ахмад настанд зориулсан нөхөн сэргээх, асран сувилах газрыг зохистой хэлбэрээр байгуулж ажиллуулах;
- Тахир дутуу иргэдэд үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээг өргөтгөж материаллаг баазыг нь бэхжүүлэх;
- Хүн амыг зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслэлээр жигд, хүртээмжтэй тасралтгүй хангах;

ДӨРӨВ. ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Говь-Алтай аймгийн хөгжлийн 2 дахь, 3 дахь, 4 дэх тэргүүлэх чиглэлүүдийг хэрэгжүүлнэ. 2008-2015 онд мэдлэгт суурилсан эдийн засгийн үндэс суурийг тавьж, нэг хүнд ногдох ДНБ-ийг 4.5 сая төгрөг буюу 3,8 мянган ам. долларт хүргэнэ. 2016-2021 онд нэг хүнд ногдох ДНБ-ийг 9 сая төгрөг буюу 7.5 мянган ам. долларт хүргэж, мэдлэгт суурилсан, экспортын баримжаатай, өөрөө өөрийгөө тэтгэдэг эдийн засгийг бий болгоно.

4.1. Макро эдийн засгийн бодлого

Нэгдүгээр үе шат (2008-2015 он):

Стратегийн зорилт 1. Эдийн засгийг энэ үе шатанд жилд дундажаар 20 хувиар өсгөж, эдийн засгийн салбарын бүтцийг эрчимтэй шинэчлэн аймгийн

ДНБ-ий 26 хувийг аж үйлдвэр барилгын салбарт, 36 хувийг ХАА-н салбарт, 38 хувийг үйлчилгээний салбарт тус тус үйлдвэрлэнэ:

- МАА-н түүхий эд, газар тариалангийн бүтээгдэхүүнийг бүрэн боловсруулах үйлдвэрүүдийг байгуулан ажиллуулж экспортын баримжаатай үйлдвэрлэлийн үндэс суурийг тавих;
- Ашигт малтмалын томоохон ордуудыг түшиглэн уул уурхайн олборлох, боловсруулах үйлдвэрүүдийг байгуулж ажиллуулах;
- Түүхий эдийн арвин нөөцдөө тулгуурлан барилгын материалын үйлдвэрүүдийг байгуулж ажиллуулах;
- Бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуй, газар тариаланг хөгжүүлж, ХАА-н бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх;
- Хүн амын хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын экологийн цэвэр бүтээгдэхүүнээр үндсэндээ хангадаг болох;
- Аялал жуулчлалыг хөгжүүлж, эдийн засгийн өсөлтөд мэдэгдэхүйц нөлөө бүхий салбар болгох;
- Зам тээвэр, эрчим хүч, мэдээлэл холбооны дэд бүтцийг хөгжүүлж үйлдвэрлэл, үйлчилгээ хөгжих, дотоод, гадаад зах зээлд гарах таатай орчин бүрдүүлэх;
- Улсын хилийн боомт, гарцуудын нэвтрүүлэн өнгөрүүлэх чадвар, үйлчилгээний чанарыг сайжруулж экспортын баримжаатай үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих;
- Бургастайн боомтыг байнгын ажиллагаатай болгох;
- Төсвийн удирдлага, санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй болгох;
- Банк, санхүүгийн үйлчилгээг боловсронгуй болгож, аймгийн хөгжлийг дэмжих сан байгуулж ажиллуулах;
- Үйлдвэрлэл, үйлчилгээнд мэдлэг, орчин үеийн менежмент, мэдээллийн технологийг тууштай нэвтрүүлэх;

Хоёрдугаар үе шат (2016-2021 он):

Стратегийн зорилт 1. Эдийн засгийг энэ үе шатанд жилд дундажаар 17 хувиас доошгүй өсгөж, аймгийн ДНБ-ий 37 хувийг аж үйлдвэр барилгын

салбарт, 20 хувийг ХАА-н салбарт, 43 хувийг үйлчилгээний салбарт тус тус үйлдвэрлэнэ:

- Өндөр технологид тулгуурласан, экспортын баримжаатай, экологийн цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлэх ;
- Уул уурхайн салбарт эрдэс баялагийг боловсруулах үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлэх;
- Барилгын материалын үйлдвэрлэлийг төрөлжүүлэн хөгжүүлж, барилгын материалыг Баруун бүсийн болон хөрш орнуудын зах зээлд нийлүүлэх ;
- Аялал жуулчлалыг эрчимтэй хөгжүүлж, аймгийн эдийн засгийн тэргүүлэх салбарын нэг болгох;

4.2. Эдийн засгийн бодит салбаруудын хөгжлийн бодлого

4.2.1. Аж үйлдвэрийн хөгжлийн бодлого

4.2.1.1. Боловсруулах аж үйлдвэрийн хөгжлийн бодлого

Нэгдүгээр үе шат (2008-2015 он):

Стратегийн зорилт 1. Боловсруулах аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлийг энэ үе шатанд жилд дундажаар 38 хувиар өсгөж, аж үйлдвэрийн салбарын ДНБ-ий 54 хувийг үйлдвэрлэж, экспортын баримжаатай боловсруулах үйлдвэрлэлийн үндэс суурийг тавина:

- Хонины болон тэмээний ноос боловсруулж оёмол, нэхмэл, сүлжмэл бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх;
- Ямааны ноолуур боловсруулах үйлдвэр байгуулан ажиллуулж бүтээгдэхүүнээ дотоод, гадаад зах зээлд нийлүүлэх;
- Арьс шир боловсруулах экспортын баримжаатай үйлдвэр байгуулж ажиллуулах;
- Мах боловсруулах экспортын баримжаатай үйлдвэр байгуулан ажиллуулах;
- Сүү боловсруулах экспортын баримжаатай үйлдвэр байгуулан ажиллуулах;
- Орчин үеийн технологиор хүнсний ногоо, жимс жимсгэнийг савлаж борлуулах;
- Газар тариалан өргөн эрхэлдэг Шарга зэрэг сумдад гурилын бага оврын үйлдвэр байгуулан ажиллуулах;

- Чацаргана, улаан хальст сармис, суль, цулихир, арвайн бүтээгдэхүүний үйлдвэрүүд байгуулан ажиллуулж, аймгийн бренд бүтээгдэхүүн үйлдвэрлэх;
- Зээргэнэ, хунчир, чихэр өвс тариалж, эмийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх;
- Аялал жуулчлалыг дагасан үйлдвэрлэл, үйлчилгээг бүх чиглэлээр хөгжүүлэх;
- “Нэг сум-нэг бүтээгдэхүүн” хөдөлгөөнийг улам эрчимжүүлэх;
- Өндөр технологи нутагшуулах төвийг байгуулан ажиллуулах;

Стратегийн зорилт 2. Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд үзүүлдэг төрийн үйлчилгээг чирэгдэлгүй, түргэн шуурхай болгоно:

- Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх хүсэлтэй иргэдийг шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах, тэдэнд техник, технологийн сонголт хийхэд нь туслах, төсөл боловсруулах, шалгаруулах явцад нь зөвлөгөө өгөх, үйлчилгээ үзүүлэх үүрэг бүхий төвийг байгуулж ажиллуулах;
- Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжиж, бизнес инкубатор байгуулж ажиллуулах;

Хоёрдугаар үе шат (2016-2021 он):

Стратегийн зорилт 1. Боловсруулах салбарын үйлдвэрлэлийг энэ үе шатанд жилд дундажаар 10 хувиар өсгөж, аж үйлдвэрийн салбарын ДНБ-ий 14 хувийг үйлдвэрлэж, экспортын баримжаатай боловруулах үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлнэ:

- Бургастайн боомтыг түшиглэн худалдааны чөлөөт бүс байгуулах;
- Алтай хотод “Алтай” үйлдвэрлэл, технологийн паркийг байгуулах ажлыг эхлүүлэх;
- Экспортын баримжаатай, оюуны шингэц бүхий өрсөлдөх чадвартай, бага оврын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх;

4.2.1.2. Геологи, уул уурхай, эрдэс баялаг, хүнд үйлдвэрийн хөгжлийн бодлого

Үндэслэл: Аймгийн хэмжээнд одоогоор ашигт малтмалын 40 орд, 375 илэрц тогтоогдоод байна. Аймаг нь нүүрс, алт, төмөр, зэс, хар тугалганы ордын илэрцүүдээр баялаг байгаа юм. Тухайлбал, 50 сая тн нөөцтэй Биндэръяагийн голын магнезитийн орд, 200-300 тн нөөцтэй Талын мэлтэсийн

алтны үндсэн орд, 80 гаруй сая тн нөөцтэй Зээгт, Хүрэн гол, Хөв булаг, Цахиурт, Мааньтын нүүрсний ордууд нээгдэн зарим нь ажиллаж байна. Цөөнгүй аж ахуйн нэгж хайгуулын лиценз эзэмшин, хэд хэдэн томоохон компани хайгуул хийж байна. Аймагт эхний ээлжинд хүрэн нүүрс, хром, төмөр, магнезит, алт, нефть олборлох, тэдгээрт түшиглэсэн боловсруулах үйлдвэрүүдийг байгуулж аймгийн эдийн засгийн хөгжлийг түргэтгэх боломж байна.

Нэгдүгээр үе шат (2008-2015 он):

Стратегийн зорилт 1. Геологи, уул уурхай, эрдэс баялаг, хүнд үйлдвэрийн салбарын ДНБ-ийг энэ үе шатанд жилд дундажаар 9 хувиар өсгөж, аж үйлдвэрийн салбарын ДНБ-ий 42 хувийг үйлдвэрлэж, энэ салбарт экспортын баримжаатай үйлдвэрлэлийн үндэс суурийг тавина:

- Ашигт малтмалын эрэл хайгуул, зураглалын ажлыг өргөтгөж эхний ээлжинд ашиглах боломжтой эрдэс баялгийн ордуудыг тогтоож ашиглаж эхлэх;
- Ашигт малтмалын ордуудыг ашиглалтад оруулахад шаардлагатай дэд бүтэц, уурхайн цогцолборыг байгуулахад дэмжлэг үзүүлэх;
- Цээл сумын Таян нуурын төмрийн хүдрийн ордыг түшиглэн төмрийн хүдэр олборлох;
- Чандманын Зээгт, Төгрөгийн Хүрэнгол зэрэг нүүрсний уурхайнуудын олборлолтыг эрс нэмэгдүүлэн Баруун бүсийн хэрэгцээг хангах, улмаар экспортлох;
- Жаргалан, Дэлгэр сум дахь Цахиур, Хөв булгийн нүүрсний уурхайг ашиглалтад оруулах;
- Нүүрснээс утаагүй шахмал түлш гаргах бага оврын үйлдвэр байгуулж ажиллуулах, бага оврын цахилгаан станцуудын түлшинд зориулан нүүрсийг хийжүүлэх, коксжуулах;
- Талын мэлтэсийн алтны ордыг ашиглах эрх зүйн орчинг бүрдүүлж, ашиглаж эхлэх;
- Шарга суманд газрын тосны, Дэлгэр суманд ураны хайгуулын ажлыг эрчимжүүлэх;
- Тайшир сум дахь цементийн түүхий эдийг түшиглэн жилд 50-100 мянган тонн цемент үйлдвэрлэх үйлдвэр байгуулан аймгийн болон Баруун бүс, хөрш зэргэлдээ аймгуудын хэрэгцээг хангах;

- Тайшир сумын хром, магнезитын ордыг түшиглэн галд тэсвэртэй барилгын материалын үйлдвэрлэл хөгжүүлэх нөхцлийг бүрдүүлэх;
- Тонхил сумын гялтгануурын орд газрыг ашиглах эхлэх бэлтгэлийг хангах;
- Тайшир, Есөнбулаг, Баян-Уул, Шарга, Бигэр, Эрдэнэ сумдын тоосгоны шаврын орд газруудыг түшиглэн тоосгоны томоохон үйлдвэр байгуулж хөрш зэргэлдээ аймгуудын зах зээлд нийлүүлэх;
- Эрдсийн түүхий эдийн боловсруулалтын түвшинг дээшлүүлж, эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх;

Стратегийн зорилт 2. Уул уурхайн салбарт байгаль орчныг хамгаалж, экологийн тэнцвэрт байдлыг хадгална:

- Уул, уурхайн ашиглалтад өртсөн талбайн нөхөн сэргээлтийг сайжруулах;
- Уурхайн олборлолтын технологид нэгдсэн стандарт мөрдүүлэх;
- Уурхайн хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах, ашигт малтмалыг далд аргаар олборлох, газрын гүнд боловсруулалт хийхийг дэмжин өргөжүүлэх;
- Эко системийн тэнцвэрт байдлыг хадгалах зорилгоор гол мөрний эх, ойн бүс, говийн баян бүрд, нуур цөөрөм, түүхийн дурсгалт газарт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгохгүй байх.

Хоёрдугаар үе шат (2016-2021 он):

Стратегийн зорилт 1. Геологи, уул уурхай, эрдэс баялаг, хүнд үйлдвэрийн салбарын ДНБ-ийг энэ үе шатанд жилд дундажаар 29 хувиар өсгөж, аж үйлдвэрийн салбарын ДНБ-ий 65 хувийг үйлдвэрлэж, экспортын баримжаатай үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлнэ:

- Эрдэс, түүхий эдийн нөөцийг иж бүрэн хаягдалгүй, байгаль орчинд халгүй ашиглах өндөр технологийг эрчимтэй нэвтрүүлэх;
- Эрдэс түүхий эдийн боловсруулалтын түвшинг ахиулж, эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх;
- Уул уурхай, хүнд үйлдвэрлэлийн цогцолборыг дагасан жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх;
- Цээл сумын Таян нуурын төмрийн хүдрийн ордыг түшиглэн төмөрлөгийн дунд хэмжээний үйлдвэр байгуулан ажиллуулах;

- Талын мэлтэсийн болон Хатан суудалын алтны ордыг байгальд халгүй технологи хэрэглэн ашиглах;
- Тонхил сумын гялтгануурын орд газрыг түшиглэсэн үйлдвэрийг бүрэн хүчин чадлын хэмжээнд ажиллуулах;
- Есөнбулаг сумын нутаг Ногоон толгой, Тайшир сумын жонгийн голын хром магнезитын орд газруудыг ашиглах;
- БНХАУ-тай хил залгаа Алтай сумын нутаг, Алтайн өвөр говьд газрын тосны эрэл хайгуул хийх;

4.2.2. Хөдөө аж ахуйн хөгжлийн бодлого

Үндэслэл: Аймгийн ХАА-д бэлчээрийн МАА-н салбар давамгайлж байна. Аймгийн нийт өрхийн 55,3 хувийг мал аж ахуй байнга эрхэлдэг малчин өрх эзэлж байгаагаас үзэхэд хүн амын амьжиргааны гол эх үүсвэр мал аж ахуйтай ихээхэн холбоотой байна. 2007 оны байдлаар аймагт 2486.6 мянган толгой мал тоолуулснаас тэмээ 227,3 мянга, адуу 71,5 мянга, үхэр 42,4 мянга, хонь 775,0 мянга, ямаа 1570,2 мянга байна. Нийт малын тоогоороо улсад 8-р байрт, бүсийн хэмжээнд 4-р байрт орж байна. Ямааны тоогоор улсад 1-р байр, тэмээний тоогоор 2-р байр, харин үхэрийн тоогоор сүүлийн байр эзэлж байна. Сүүлийн жилүүдэд мал сүргийн уламжлалт бүтэц эвдэрч, ямаан сүргийн эзлэх хувь 2002 онтой харьцуулахад 2 дахин өсч нийт малын 63,1 хувийг, хонин сүргийн тоо 2 дахин буурч, нийт малын 31,2 хувийг эзлэх болов. Мал сүргийн дотор арвин ашиг шимтэй эрлийз болон үржлийн шилмэл малын тоо толгой цөөн байна. Бэлчээрийн усан хангамж 69.4 хувь байна.

Жилд дунджаар тэмээний ноос 130,0 тн, хонины ноос 750,0 тн, ямааны ноолуур 302,0 тн, ямааны хялгас 170,0 тн, үхрийн хялгас 8,0 тн, хөөвөр 12,0 тн, тэмээний шир 5,0 мян.ш, адууны шир 15,0 мян.ш, үхрийн шир 8,0 мян.ш, хонины арьс 180,0 мян.ш, ямааны арьс 200,0 мянган ширхэг тус тус бэлтгэж байна. Гэтэл зөвхөн ноос хагас боловсруулж, эсгий хийхээс өөр үйлдвэрлэл байхгүй байна.

1980-1990 онд 17 инженерийн хийц бүхий услалтын системтэй, 5547 га эргэлтийн талбайд газар тариалангийн үйлдвэрлэл явуулж байв. Өнөөгийн байдлаар 3598 га-гийн төслийн хүчин чадал бүхий 9 услалтын системийг ашиглан 1550 га-д тариалалт хийж байна. Аймгийн хэмээнд 2007 оны байдлаар үр тариа 676,0 тн, төмс 1390,3 тн, хүнсний ногоо 519,5 тн нийт

2581,0 тн ургац хураан авчээ. Төмс, хүнсний ногооны хэрэгцээнийхээ 35-43 хувийг дотооддоо үйлдвэрлэж байна. Малын тэжээлийн ургамал 400-гаад га-д тариалж, хязгаарлагдмал нөөц бүхий усалгаатай талбайгаас жилд дундажаар 4000-5000 тн хадлан, 400 тн гар тэжээл бэлтгэж байгаа нь хэрэгцээний дөнгөж 9 хувийг хангаж байна. Мөн бага хэмжээгээр алим, лийр, чавга, чацаргана зэрэг жимс жимсгэнэ тариалдаг уламжлалтайн дээр хөх тариа, улаан хальст сармис, хар будаа, усан үзэм зэрэг шинэ нэр төрлийн хүнсний ургамал болон зээргэнэ, хунчир, чихэр өвс, лидэр зэрэг эмийн ургамал тариалж эхлээд байна.

Аймагт улаан буудайгаар гурил хийх бага оврын гурван цех ажиллаж хэрэгцээт гурилынхаа 8 хувийг хангаж байна. Уламжлалт халтар арвайн тариалалтыг нэмэгдүүлж “Ашвай” нэртэй жигнэмэг хийж аймгийн бренд бүтээгдэхүүн болгоод байна. Мөн жимс, жимсгэний тариалалтыг үргэлжлүүлэн, дарс, ундаа, чацарганы тосны үйлдвэрлэлийг нэмэгдүүлж байна.

Цаашид говийн нөхцөлд услалтын системийг улам өргөжүүлэх, талбайн хэмжээг нэмэгдүүлэх, га-гийн ургацыг өсгөх замаар газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлэх шаардлагатай байна.

Нэгдүгээр үе шат (2008-2015 он):

Стратегийн зорилт 1. Бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг хослуулан хөгжүүлж, малын үүлдэрлэг чанарыг сайжруулан ХАА-н салбарын үйлдвэрлэлийг энэ үе шатанд жилд дундажаар 10 хувиар өсгөнө:

- Говь-Алтай аймгийн МАА-г эрчимжүүлэн хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж хэрэгжүүлэх;
- Аймгийн мал сүргийн бүтцийг зохистой хэмжээнд байлгах бодлогыг хэрэгжүүлэх;
- Говь-Алтай үүлдрийн болон байдраг, барга, үзэмчин, торгууд хонь, хэцийн хүрэн, төхөм тунгалагийн хос зогдорт хүрэн тэмээ, говь-гурван сайхан-нутгийн ямаа, алтай нутгийн улаан ямаа, өлгийн-нутгийн улаан ямаа, тулман хөхөт-нутгийн ямаа болон гал шар, тэсийн хурдан адуу, “алатау” нутгийн үхэр зэрэг өндөр ашиг шимт үүлдрийн мал сүргийн эзлэх хувь хэмжээг эрс нэмэгдүүлэх;
- Мянганы замын босоо тэнхлэгийн дагуу болон зарим бүс нутаг, төв суурин газруудад мах, сүүний чиглэлийн үхэр, ямаа, махны чиглэлийн хонь болон гахай, тахиа, зөгий, туулайн аж ахуйг хөгжүүлэх;

- Бигэрийн Мянгай, Чандманы Хүрхрээ, Дэлгэрийн Дагналтай, Цогтын Баянтоорой, Хаяа, Халиун сумын Ёлтонгийн услалтын системүүд, Шарга сумын хадлангийн талбайг түшиглэн эрчимжсэн загвар фермерийн аж ахуйг байгуулж, цаашид бүх сумдад хөгжүүлэх;
- Үүлдэр, омог, гойд ашиг шимт малыг богино хугацаанд өсгөхийн тулд биотехнологийг өргөн нэвтрүүлэх, малын үржлийн биологийн лаборатори байгуулах;
- Халиун, Төгрөг, Шарга, Бигэр сумдад ингэ, цагаан гүү, ямааны сүүний сувилал, эмчилгээний цэгүүдийг нээн ажиллуулах;
- Газар тариалан, мал аж ахуй хосолсон эрчимжсэн фермерийн загвар аж ахуй байгуулах санаачилгыг бүх талаар дэмжих;
- Мал эмнэлэг, үржлийн үйлчилгээг боловсронгуй болгож, материалаг бааз, боловсон хүчний хангамжийг нь сайжруулах;
- Мал эрүүлжүүлэх чиглэлээр малчин, малын эмч, засаг даргын хамтарсан гэрээг сайжруулж, хариуцлагыг дээшлүүлэх;
- Өвөлжөө, хаваржааны бэлчээрийг худаг, уст цэгийн хамт малчдын бүлгүүдэд оновчтой хэлбэрээр эзэмшүүлэх;
- Бэлчээрийн байдал, усан хангамжийн хүрэлцээний судалгаа үзлэгийг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, үнэлгээ дүгнэлт гаргуулан бэлчээрийг зохистой ашиглах;
- Гуулин, Баянтоорой, Бигэр, Шарга, Халиун болон бусад боломжтой сумдад тэжээлийн ургамал тариалахын зэрэгцээ тэжээлийн жижиг үйлдвэрийг хөгжүүлэх;
- Тэргүүний малчдын зөвлөгөөнийг төрөлжүүлэн явуулж малчдыг ажлын арга туршлагаа солилцох, суралцах, өндөр ашиг шимт мал олж авах, үржлийн шилмэл малаа сурталчилах зэрэг арга хэмжээнд хамруулах;
- Сум бүрд ашиглагдаагүй бэлчээрт худаг, уст цэг гаргах, хурын ус хуримтлуулан усан сан, хөв байгуулах;
- Малчид, МАА-н усан хангамжийн хүрэлцээг нэмэгдүүлэх зорилгоор гүний худаг гаргалтыг 2 дахин нэмэгдүүлэх;
- Худаг гаргаж бэлчээр ашиглалтыг сайжруулсан иргэд, малчдыг эдийн засгийн аргаар урамшуулах;

- Улаан шалын хоолойд усны хайгуул хийж, гүн өрмийн худгууд гарган бэлчээрийн талбайг нэмэгдүүлэх нөхцлийг бүрдүүлэх;
- Усны нөөцийг нэмэгдүүлэх зориулалттай гидротехникийн байгууламжуудыг бий болгох;

Стратегийн зорилт 2. Газар ашиглалтыг сайжруулж, усалгаатай тариалан, хүлэмжийн аж ахуйг хөгжүүлнэ:

- Биотехнологи эвтрүүлэн газар тариалангийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх;
- “Говь-Алтай аймгийн газар тариаланг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр” “Атрын III аян”, аймгийн “Ногоон хувьсгал-II” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх;
- Хүрхрээ, Тээл, Намалзах, Мянгай, Бургас, Биж, Хоёр байшинт, Харгана түрүү, Тахийн тал, Шаргын услалтын системүүдийг сэргээн засварлаж ашиглах;
- Ёлтон, Дагналтай, Хаяа, Шугуй, Гуулин, Хуримтын услалтын системүүдийн ашиглалтыг сайжруулах;
- Атаршсан талбай болон хөрсний судалгааг сум бүрээр хийж, жил бүр 500 га-аас доошгүй атаршсан талбайг тариалангийн эргэлтэнд оруулан нийт эргэлтийн талбайн хэмжээг өргөтгөх;
- Хүнсний ногооны хэрэгцээг 2012 онд 70-80 хувь, 2015 онд 100 хувь, гурилын хэрэгцээг 2012 онд 20 хувь, 2015 онд 30-40 хувь хангадаг болох;
- Усалгаатай нөхцөлд өндөр ургац өгдөг сортын үр тариа, тэжээлийн ургамлыг Баянтоорой, Бигэр, Чандмань, Халиун, Гуулин, Бугат, Шарга, Жаргалан зэрэг сумдад тариалах;
- Хөх арвайн олон зүйл омгийг судалж туршин өндөр үр ашигтай сортыг сонгон тариалах;
- Үр тариа, тэжээлийн ургамлын үрийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, тариалан эрхэлж буй иргэдэд дэмжлэг үзүүлэх;
- Төмсний үрийн чанарыг сайжруулж, 1 га-аас 100 цн-ээс доошгүй ургац авах боломжтой “Астила”, Импилл, Витара зэрэг сортын төмсний үр үйлдвэрлэгчдийг дэмжих;
- Чихэр өвс, хунчир, зээргэнэ зэрэг эмийн ургамлын тариалалтыг 500 га-д хүргэн, эмийн угтвар бодисын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх;

- Улаан хальст сармисны үр үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, тариалалтыг өргөтгөх;
- Жимс жимсгэнийн тариалалтыг өргөтгөх;
- Сум бүрт хүлэмжийн аж ахуй байгуулан хүнсний нарийн ногоо тариалах хөдөлгөөн өрнүүлэх;
- Гуулин, Дагналтайн услалтын системийг түшиглэсэн газар тариалан, мод үржүүлгийн үйлдвэрлэлийг цахилгаанаар хангах;
- Агрономич, механикжуулагч мэргэжилтнүүдийг давтан сургалтанд хамруулах, шинээр боловсон хүчин бэлтгэх;
- Мэргэжилтэй ногоочид, тракторч-фермерүүд бэлтгэдэг ангийг МСҮТ-ийг түшиглэн нээж ажиллуулах;
- Шинээр сургууль төгсөж ирсэн залуу боловсон хүчнүүдийг сум орон нутагт тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бололцоог хангах ;
- Монголын хөдөөг шинэчлэх фермерүүдийн холбооны салбар зөвлөлийг байгуулж энэ холбооны хүрээнд агрономичдын клуб байгуулж төрөл бүрийн сургалтанд хамруулах

Хоёрдугаар үе шат (2016-2021он):

Стратегийн зорилт 1. Биотехнологийг тууштай нэвтрүүлж, малын үүлдэрлэг чанарыг сайжруулж, тарималын ургацыг нэмэгдүүлэн ХАА-н салбарын үйлдвэрлэлийг энэ үе шатанд жилд дундажаар 6 хувиар өсгөнө:

- Биотехнологи хэрэглэн малын эм, ариутгал, халдваргүйжүүлэгч бэлдмэлийн үйлдвэрлэлийг хөгжүүлэн мал сүргийг эрүүлжүүлэх;
- Усалгаатай газар тариаланд орчин үеийн технологийг өргөн нэвтрүүлж, техник тоног төхөөрөмжийг лизингээр олгох тогтолцоог бүрдүүлэх, га-аас авах ургацыг нэмэгдүүлэх;
- Хөдөө аж ахуйг харилцан бие биенээ тэтгэсэн бүтэц бүхий хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн цогцолбор болгон хөгжүүлэх;
- Малчдын түлш, эрчим хүчний хангамжийг сайжруулах;

4.2.3. Аялал жуулчлалын салбарын хөгжлийн бодлого

Үндэслэл: Говь-Алтай аймгийн унаган төрхөөрөө байгаа онгон дагшин уулс, говь цөл, тал хээр, нүүдэлчдийн өвөрмөц ахуй, зан үйл, түүх, соёлын эртний дурсгалууд нь дотоод, гадаадын жуулчдын сонирхолыг ихээхэн татдаг.

Нийт нутаг дэвсгэрийн 25,6 хувь нь улсын тусгай хамгаалалттай газар нутаг хамрагддаг. Энд дэлхийд ховордсон олон зүйлийн ургамал, амьтан бүртгэгдсэн байна. Гэвч өнөө хүртэл аялал жуулчлал шаардлагын хэмжээнд хүртэл хөгжөөгүй байна. Жуулчид хүлээн авах шаардлага хангасан зочид буудал, жуулчны бааз, зоогийн газар, үзвэрийн газрууд байхгүй, үйлчилгээний чанар, нэр төрөл тун хангалтгүй, мэрэгжилтэй боловсон хүчний хүрэлцээ, жуулчин хүлээн авах даац, сурталчилгаа дутмаг байгаа нь аялал жуулчлал хурдан хөгжихөд саад болж байна. Аймагт аялал жуулчлалыг 1) Байгаль экологийн аялал жуулчлал, 2) Тvvх соёлын дурсгалт зvйлийг сонирхох аялал жуулчлал, 3) Өвлийн улирлын аялал жуулчлал гэсэн хэд хэдэн чиглэлээр хөгжүүлэх боломж байна.

Нэгдүгээр үе шат (2008-2015 он):

Стратегийн зорилт 1. Аялал жуулчлалын салбарын жилийн дундаж өсөлтийг 13 хувьд, үйлчилгээний салбарын үйлдвэрлэлд аялал жуулчлалын салбарын эзлэх хувийн жинг 63 хувьд хүргэж аймгийн эдийн засгийн тэргүүлэх салбарын нэг болгоно:

- Говь-Алтай аймагт аялал жуулчлал хөгжүүлэх хөтөлбөр(2002 он)-ийн хэрэгжилтийг эрчимжүүлэх;
- Экологийн аялал жуулчлалыг дараах маршрутаар хөгжүүлэх:
 - Алтай хот- Хvнхэр амралт- Жаргалангийн сvмийн дэнгийн хvн чулуун хөшөө- Эрээн, Ажиг нуур- Долоон тогооны талын агуй-Сэнжид хад- Тайширын УЦС-Завхан голын Шохойн булан- Шар булаг- Алтай хот;
 - Алтай хот- Бигэрийн улаан явар- Таван элсний бөөрний сувилал- Цагаан хаалганы рашаан- Бурхан буудай уул- Найтаастийн бичигт хад- Ээж уул- Хаяагийн говь, услалтын систем- Буурийн гол давсны орд газар- Цагаан голын бичигт хад- Алтай хот;
 - Алтай хот- Шаргын хар заг- Цагаан нуур- Сутай- Гурван хулд- Тахь нутагшуулах төв- Бижийн амны далан- Ширтийн агуй- Алаг нуурын говь- Шvvтийн хавцал- Алтай хот;
- Баруун бүсийн бусад аймгийн аялал жуулчлалын маршруттай холбон Хамтын аялал жуулчлал (Community based tourism), спортын аялал жуулчлалыг тууштай хөгжүүлэх;
- Аялал жуулчлалын цогцолбор, бааз байгуулах төслүүдийг боловсруулж, дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдад санал болгох;

- Аялал жуулчлал хөгжүүлэх бүсүүдэд дотоод, гадаадын жуулчид, анчдыг хүлээн авах олон улсын зэрэглэлийн зочид буудал, жуулчдын бааз, түр буудаллах дэн буудлын сүлжээ байгуулахыг дэмжих;
- Аялалын тогтоосон маршрутын дагуух авто замыг засварлаж, тэмдэгжүүлэх;
- Жуулчдын баазын ойролцоо угсаатны зүйн болон бусад зан үйлийг сонирхуулах, эмнэг мал сургах, эсгий хийх, цагаан идээ боловсруулах, морин аялал хийх, үзэсгэлэн гаргаж үзүүлэх зэрэг арга хэмжээг өргөн зохион байгуулах, энэ чиглэлээр сурталчилгаа явуулах;
- Байгальд халгүй, орчин үеийн технологид суурилсан эрчим хүчний эх үүсвэрээр жуулчны үйлчилгээний газруудыг хангах арга хэмжээ авах;
- Тайширын УЦС-ын нуурыг түшиглүүлэн аялал жуулчлалыг хөгжүүлэх;

Стратегийн зорилт 2. Аялал жуулчлалын материаллаг баазыг бэхжүүлэн, менежментийг нь боловсронгуй болгоно:

- Одоо ажиллаж байгаа жуулчдын бааз, амралт, сувилалын газруудыг тохижуулах, шинээр байгуулах замаар жилд 10-15 мянга хүртэл жуулчин хүлээн авах хүчин чадалтай болгох;
- Аялал жуулчлалын маршрутын авто замыг сайжруулах зорилтыг дэд бүтцийн хөгжлийн хөтөлбөрүүдтэй нягт уялдуулан хэрэгжүүлэх;
- Музейн үзмэрүүдийг баяжуулах, аялал жуулчлалын маршрутын дагуух түүх соёлын үнэт зүйлсийг сэргээн засварлах;
- Аялал жуулчлалын отог, баазуудын менежментийг сайжруулах зорилгоор ажиллагсдыг нь төрөлжсөн сургалтад хамруулах, мэргэжилтэй боловсон хүчнээр хангах;

Хоёрдугаар үе шат (2016 – 2021 он):

Стратегийн зорилт 1. Аялал жуулчлалын салбарын хөгжлийг эрчимжүүлж, үйлчилгээний чанарыг олон улсын жишигт хүргэн үйлчилгээний салбарт аялал жуулчлалын салбарын эзлэх хувийн жинг 68 хувьд хүргэнэ:

- Аймагт жил бүр хүрэлцэн ирэх жуулчдын тоог аймгийн хүн амын тоотой тэнцэх хэмжээнд хүргэх;
- Орчин үеийн зочид буудал, жуулчны бааз, нүүдлийн отог шинээр барьж тохижуулан үйлчилгээний нэр төрлийг олшруулах;

- Бигэр номунхан, Наробанчин хийдийг сэргээн босгож, шашин, соёл, жуулчны төв болгох;
- Аялал жуулчлалын бүх төрлийн үйлчилгээний стандартыг боловсронгуй болгож, хяналтыг сайжруулах;

4.3. Дэд бүтцийн хөгжлийн бодлого

Говь-Алтай аймгийн хөгжлийн 3 дахь тэргүүлэх чиглэлийн хүрээнд:

Говь-Алтай аймагт дэд бүтэц нэн сул хөгжсөн байна. Агаарын болон авто тээврээр нийслэл хот болон бусад аймгуудтай холбогддог. Агаарын тээврийн үйлчилгээ тогтмолжоогүй байна. Говь-Алтай аймагт эрчим хүч байнга дутагдаж байдаг бөгөөд төвийн эрчим хүчний системд холбогдоогүй, дизель ихэнхи станцаар хэрэгцээгээ хангадаг цөөхөн аймгийн нэг. Харин сүүлийн жилүүдэд мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээ түргэн хөгжиж байна.

4.3.1. Зам, тээврийн хөгжийн бодлого

Үндэслэл: Аймагт авто замын сүлжээний хөгжлийн түвшин ихээхэн доогуур байна. Орон нутгийн чанартай авто замын урт нь 2478 км байна. Аймгийн төвд 17 км хатуу хучилт бүхий авто зам байна. Ховдын чиглэлд 180 км сайжруулсан замтай. Хөрөнгө, хүч ихээхэн шаардсан Алтай хот -Улиастай, Алтай хот-Баянхонгорын чиглэлийн замд хөрөнгө оруулах асуудал чухлаар тавигдаж байна. Өнөөгийн байдлаар аймагт агаарын тээврийн үйлчилгээ хязгаарлагдмал байгаа нь иргэдийн зорчих хөдөлгөөнд ихээхэн бэрхшээл учруулж байна. Нисэх онгоц хөөрөх, буух зурвасыг яаралтай хатуу хучилттай болгох шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Зорчигч, ачаа тээвэрлэлтийг авто тээврийн хэрэгслээр гүйцэтгэж байгаа бөгөөд зорчигчдын тав тухтай байдлыг хангах, зам тээврийн элдэв осол, гэмтлээс хамгаалах, замын хяналтыг тогтмолжуулах зэрэг асуудлуудыг шийдвэрлэх шаардлагатай байна. Ачаа тээвэрлэлтийн үйлчилгээг сайжруулах шаардлагатай байна.

Нэгдүгээр үе шат (2008-2015 он):

Стратегийн зорилт 1. Аймгийн авто замын сүлжээг сайжруулж зарим чиглэлийн замыг хатуу хучилттай болгоно:

- “Мянганы зам” байгуулалтын хүрээнд Ханх-бургастайг холбосон босоо тэнхлэгийн авто замыг барьж эхлэх;
 - Өвөрхангай-Баянхонгор-Говь-Алтайн чиглэлээр хатуу хучилттай зам тавих;
 - Цээлийн Таян-нуурын төмрийн хүдрийн ордоос Бургастай хүртэл хатуу хучилттай зам тавих;
 - Ховдын хөшөөтийн нүүрсний орд руу тавьж буй хатуу хучилттай замыг Говь-Алтайн Хүрэн голын нүүрсний ордтой холбох;
 - Автозамын салбарыг хөгжүүлэхэд улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөс гадна гадаадын хөрөнгө оруулагчид, хувийн хэвшлийн оролцоо, хөрөнгө оруулалтыг бүх талаар урамшуулан ашиглах;
 - Аймгийн авто замын нэгдсэн сүлжээний зураглалыг шинэчлэн боловсруулж мөрдүүлэх;
 - Алтай хот доторхи хатуу хучилттай замыг шинэчлэн сайжруулах;
 - Зам, гүүрийн барилгын техник хэрэгслийн хангамжийг урт хугацааны бага хүүтэй зээл (лизинг)-ээр дэмжин сайжруулах;
 - Алтай- Бургастайн боомт гэсэн чиглэлээр автозам тавих ажлыг эхлүүлэх;
- Стратегийн зорилт 2.** Агаарын тээврийн үйлчилгээг өргөтгөн сайжруулна:
- Аймгийн төвийн Нисэх буудлыг шинэ байртай болгон үйлчилгээний чанарыг сайжруулах;
 - Онгоцны хөөрөх, буух зурвасыг шинэчлэн сайжруулж, хатуу хучилттай болгох;

Хоёрдугаар үе шат (2016-2021 он):

Стратегийн зорилт 1. Авто замын сүлжээг өргөтгөн, агаарын тээврийг эрчимтэй хөгжүүлнэ:

- Олон улсын зорчигч болон ачаа тээврийн онгоц хүлээн авах нөхцлийг бүрдүүлэх;
- Бусад аймгийн төвүүд болон хилийн боомт, уул уурхайн зарим ордуудтай холбосон хатуу хучилттай зам тавих ажлыг дуусгах;
- Баруун бүсэд байгуулагдах төмөр замын сүлжээнд холбох;

4.3.2. Эрчим хүчний салбарын хөгжлийн бодлого

Үндэслэл: Аймагт Тайширын 11 мегаваттын хүчин чадалтай усан цахилгаан станц барих ажил дуусаад байна. Эндээс эх авсан 495 км урттай

цахилгаан дамжуулах агаарын шугам барьж байна. Бугат, Цээл сумдад нар салхины цахилгаан станцууд баригдаж ашиглалтад орж байна. Эдгээр төслүүд амжилттай хэрэгжсэнээр тус аймгийн нийт сумд эрчим хүчний сүлжээнд холбогдон эрчим хүчний найдвартай эх үүсвэртэй болж үйлдвэрлэл, үйлчилгээ хөгжих таатай орчин бүрднэ. Хөдөөгийн малчин өрхийн цахилгааны эх үүсвэрийг “Буман нарны гэрэл” Засгийн газрын хөтөлбөрийн хүрээнд шийдвэрлэж байна. Гэвч аймгийн эрчим хүчний нэгдсэн системийг бүрдүүлж, эдийн засаг, нийгмийн хөгжлийн таатай орчин бүрдүүлэх шаардлагатай байна.

Нэгдүгээр үе шат (2008-2015 он):

Стратегийн зорилт 1. Эрчим хүчний салбарын үйлдвэрлэлийг энэ үе шатанд жилд дундажаар 5 хувиар өсгөнө:

- Аймгийн эрчим хүчний системийг Төвийн болон Баруун бүсийн эрчим хүчний системд холбох;
- Хөрөнгө оруулалтын өгөөжийг тооцоолсны үндсэн дээр эрчим хүчний салбарын шинэчлэл, хөрөнгө оруулалтын төслүүдийг хэрэгжүүлж сумдын халаалтын тогоонуудад шинэ дэвшилтэт техник технологи нэвтрүүлж, техникийн шинэчлэл хийх;
- Алтай хотод төвлөрсөн дулааны станц байгуулах;
- Тайширын УЦС-ыг бүрэн хүчин чадлаар нь үр ашигтай ажиллуулах;
- 10 хүртэл МВт-ын хүчин чадалтай салхин парк байгуулж, эрчим хүчний хангамжийг найдвартай болгох;
- Бугат, Алтай сумын төв, Баян-Тоорой тосгонд нарны, Цээл суманд нар-салхи хосолсон сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр суурилуулж үйл ажиллагааг нь жигдрүүлэх;
- Алтай хот-Шарга-Дарвийг 35 кВ-ын, Алтай хот-Бигэрийг 35 кВ-ын, Алтай хот-Халиун сумыг 15 кВ-ын, Тайшир-Жаргаланг 35 кВ-ын, Жаргалан-Баян-Уулыг 15 кВ-ын, Дарви-Тонхилыг 15 кВ-ын, Чандмань-Бигэрийг 35 кВ-ын, Чандмань-Эрдэнийг 10 кВ-ын, Халиун-Цээл сумыг 15 кВ, Бигэр-Цогтыг 15 кВ-ын, Ховдын Дарви-Хөхморьт сумыг 15 кВ-ын шугамаар тус тус холбох;

Хоёрдугаар үе шат (2016-2021 он):

Стратегийн зорилт 2. Эрчим хүчний менежментийг боловсронгуй болгож, байгаль орчинд халгүй тэргүүний техник технологи нэвтрүүлж, үйлдвэрлэл, хэрэглээний үр ашгийг сайжруулна:

- Чандмань сумын Зээгт, Төгрөг сумын Мааньт, Хүрэн голын уурхайг түшиглэн дулааны болон хийн цахилгаан станц байгуулах боломжийг судалж хэрэгжүүлэх;
- Сумдын түвшинд бага оврын халаалтын зуух бүхий хэрэглэгчдийг дулааны эрчим хүчний нэгдсэн системтэй холбох;
- Аймаг, сумдын хуучирсан дулааны шугам сүлжээг шинэчлэх, өргөтгөх;
- Хөдөөгийн малчин айл өрхийг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр бүрэн хангах ажлыг дэс дараатай хэрэгжүүлэх;
- Нарны илчээр ус, агаар халаах технологи, тоног төхөөрөмжийг өргөн ашиглах;
- Нүүрснээс утаагүй түлш үйлдвэрлэх бага оврын үйлдвэрүүд байгуулж ажиллуулах;

4.3.3. Мэдээлэл, харилцаа холбооны салбарын хөгжлийн бодлого

Үндэслэл: Монгол улсын мэдээлэл холбооны суурь сүлжээнд Есөнбулаг сум нь шилэн кабель /Улиастай хотоос/-аар холбогдон, улс, хот хоорондын орох, гарах яриаг автоматаар гүйцэтгэж байна. Аймгийн төв, 11 сум, сууринд үүрэн телефоны сүлжээ ашиглалтанд орсноор 12-13 гаруй мянган хүн буюу аймгийн нийт хүн амын 18 хувь нь Мобиком, Юнител, Скайтел, Ж-мобайлийн үүрэн телефоны утас хэрэглэж байна. Гэвч зарим сумдад факс, интернетийн үйлчилгээ хүлээн авах боломжгүй байна. Бүх сумдад олон сувгийн телевизийн станц ашиглалтад орсон бөгөөд аймгийн төвд кабелийн нэг телевиз, орон нутгийн олон нийтийн радио, телевиз үйл ажиллагаа явуулж байна. Шуудангийн үйлчилгээг хөдөөгийн иргэдэд шуурхай хүргэх боломж бага байна. Цаашид өндөр хурдны сүлжээ тоон системийг бүрэн нэвтрүүлэх, хөдөлгөөнт холбоог ашиглан баг, хот айл, малчдыг холбоожуулах, мэдээллийн технологийг айл өрхөд хүргэх, холбоо мэдээллийн нэгдсэн сүлжээг бий болгох, хиймэл дагуулын болон бага багтаамжийн радио релейн шугам, хөдөлгөөнт холбоог ашиглан баг, хот айл, малчдыг холбоожуулах шаардлагатай байна.

Нэгдүгээр үе шат (2008 – 2021 он):

Стратегийн зорилт 1. Мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтэц, сүлжээг шинэчлэх замаар “Мэдээлэлжсэн нийгэм”-ийг хөгжүүлэх нөхцлийг бүрдүүлнэ:

- Монгол улсын мэдээлэл, харилцаа холбооны улс хоорондын суурь сүлжээнд Есөнбулаг сумыг бие даасан, нөөц бүхий дамжуулах сүлжээгээр холбох;
- “Цахим Монгол” хөтөлбөрийн зорилт, арга хэмжээг аймаг, сумдад бүрэн хэрэгжүүлэх;
- Өвөрхангай-Говь-Алтай чиглэлийн шилэн кабелийн дамжуулах сүлжээг байгуулах;
- Хэвлэлийг электрон хэлбэрээр хүргэж, хэвлэх ажлыг зохион байгуулах;
- Аймгийн хэмжээнд бүх нийтийн компьютержүүлэлт, өрх бүрт интернет дэд хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх;
- Бүх сумдын төвд интернет цэг, интернет кафе байгуулж үйлчлэх;
- Бүсчлэлийн нэгдсэн (ZIP) кодыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, энгийн хэрэглээ болгох;
- Бүх сумдад 10-оос доошгүй сувгийн телевизийн нэвтрүүлэг үзэх боломж нөхцлийг бүрдүүлэх;
- Орон нутгийн телевизийг аймгийн нутаг дэвсгэрийг хамарсан мэргэжлийн телевиз болгон хөгжүүлэх;

Стратегийн зорилт 2. Сумдын мэдээлэл, харилцаа холбооны дамжуулах сүлжээг шилэн кабель, сансрын холбоо, радио холбооны технологиор шинэчлэнэ:

- Бүх сумдын иргэд малчдад утасгүй холбоо, үүрэн телефоны үйлчилгээг хүргэх;
- Шуудан холбооны сүлжээг ашиглан орчин үеийн шинэ төрлийн электрон үйлчилгээ болон хэрэглээг нэвтрүүлэх, сумын багийн шуудан хүргэлтийн давтамжийг нэмэгдүүлэх;
- Аймаг ба сумын дамжуулах болон холбох байгууламжийг тоон технологид бүрэн шилжүүлэх;

Стратегийн зорилт 3. Мэдээлэл, харилцаа холбооны шинэ үйлчилгээ хэрэглээг төр, аж ахуйн болон үйлчилгээний бүхий л байгууллагуудад өргөн нэвтрүүлнэ:

- Аймгийн төвийн төр, захиргаа, аж ахуйн нэгж байгууллагыг нэгдсэн сүлжээнд холбож, мэдээллийн санг бүрдүүлэх;
- Аймгийн төв, зарим сумдын төвийн эмнэлэг, сургуулийг мэдээлэл, харилцаа холбооны нэгдсэн сүлжээнд холбох;
- Электрон засаглал, электрон арилжаа, электрон гарын үсэг, шинэ төрлийн үйлчилгээг нэвтрүүлэх;

Стратегийн зорилт 4. Аймгийн хэмжээнд мэдээлэл, харилцаа холбооны мэргэжилтэн бэлтгэх чадавхийг бүрдүүлэн, хүний нөөцийг хөгжүүлнэ:

- Мэдээлэл, холбооны хэрэглээ, үйлчилгээг хүүхэд, өндөр настан, эмэгтэйчүүд болон нийгмийн эмзэг бүлэгт хүргэх сургалтын арга хэмжээнүүд зохион байгуулах;
- Мэдээлэл харилцаа холбооны өндөр ур чадвартай мэргэжлийн боловсон хүчин, инженер, техникийн ажилтнуудыг бэлтгэх, давтан сургах, улмаар гадаад орнуудад гэрээгээр ажиллах нөхцлийг бүрдүүлж, дэмжих;

4.4. Хот байгуулалт, барилгын салбарын хөгжлийн бодлого

Хот суурин газруудыг ерөнхий төлөвлөгөөний дагуу эрчимтэй хөгжүүлнэ. Барилгын салбарын үйлдвэрлэлийг эхний үе шат (2008-2015 он)-нд эрчимтэй өсгөж, аймгийн ДНБ-д эзлэх хувийн жинг 2015 онд 3.3 хувьд хүргэж 2.5 дахин нэмэгдүүлнэ. Хоёрдугаар үе шат (2016-2021)-нд барилгын салбарын үйлдвэрлэлийг жилд дундажаар 10 хувиар өсгөнө.

Нэгдүгээр үе шат (2008-2015 он):

Стратегийн зорилт 1. Алтай хотыг эрчимтэй хөгжүүлнэ:

- Алтай хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн хэрэгжүүлэх;
- Сум бүрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг орчин үеийн хот байгуулалтын бодлоготой уялдуулан боловсруулж хэрэгжүүлэх;
- Швейцарийн холбооны улсын Юра мужтай тогтоосон хамтын ажиллагааны хүрээнд аймгийн 1 сумыг тодорхой үзүүлэлтээр сонгон авч загвар сум болгон хөгжүүлэх;
- Багийн төв, ялангуяа суурьшимал багийн төвийг оновчтой тохижуулах;
- Хот суурин газруудад хэсэгчилсэн төлөвлөгөөний дагуу инженерийн дэд бүтцийг сайжруулах;
- Аймгийн төв, сумдын төвийг болон бусад томоохон суурин газруудыг дулаан, цэвэр ус, ариутгах татуургын нэгдсэн системтэй болгох;

Стратегийн зорилт 2. Орон нутгийн түүхий эдэд тулгуурласан барилгын материалын үйлдвэрүүдийг байгуулан хөгжүүлнэ:

- “Аймгийн барилгын салбарыг хөгжүүлэх мастер төлөвлөгөө”-г эрчимтэй хэрэгжүүлэх;
- Барилга, барилгын материалын судалгааны Баруун бүсийн төвийг байгуулан ажиллуулах;
- Аймгийн нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд геологийн 1:50000-ын масштабын, зарим нутагт нарийвчилсан судалгаа хийж ашиглах боломжтой эрдэс түүхий эдийн орд, илэрцийг нээж ашиглах;
- Тэргүүлэх чиглэлийн үйлдвэрүүдээс эхний ээлжинд цементийн үйлдвэр, улмаар галд тэсвэртэй барилгын материалын үйлдвэр байгуулах;
- Бетон, төмөр бетонон эдлэхүүн, дүүргэгч материал, тоосгоны үйлдвэрүүдийг сэргээн технологийг нь боловсронгуй болгох;
- Шинээр нээгдсэн болон нарийвчилсан хайгуул хийгдсэн орд газруудын түүхий эдийг ашиглан шинэ нэр төрлийн барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлэх;
- Хөөсөн полистрол хавтан, шилэн багцтай цонх, хаалга, дээврийн элс-цементэн хавтанцар, ханын бетон гулдмай, өнгөлгөөний материалын бага, дунд хүчин чадлын үйлдвэрлэлийг хөгжүүлэх;
- Энгийн хялбар технологиор шохой, гөлтгөнөт эдлэхүүн, эрдэс будаг, зам талбай, засал чимэглэл, тохижилтийн жижиг бүтээц эдлэлийг үйлдвэрлэх;
- Бетоны өргөн хэрэглээтэй /аймгийн төв гэх.мэт/ төв суурин газруудад дүүргэгч материалын нэгдсэн карьер, бетон зуурмагийн төвлөрсөн узел ажиллуулах;
- Олон давхар болон томоохон барилгын ажлыг гүйцэтгэх чадавхийг бий болгох;
- Сум бүрийг барилгын засварын ажлыг гүйцэтгэх чадамжтай болгох;
- Шаталсан сургалттай барилгын мэргэжлийн коллеж, цаашид шаталсан сургалттай Барилгын инженерийн сургууль байгуулах;
- Бидэрийн голын магнезитийн ордыг түшиглэн үйлдвэр байгуулах;

Стратегийн зорилт 3. Хүн амын өсөлт, орон сууцны хэрэгцээтэй уялдуулан аймгийн орон сууцны хангамжийн түвшинг дээшлүүлнэ:

- “40 000 айлын орон сууц” хөтөлбөрийн хүрээнд аймгийн төвд орон сууцны шинэ хороолол бий болгох;
- “Орон сууц” сан бүрдүүлж, эн түрүүнд төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний салбарын албан хаагчид, залуу гэр бүлийг орон сууцаар хангах;
- Амины орон сууц барьж буй иргэдийг хөнгөлөлттэй зээлээр дэмжих;
- Сумдын төвийг баталгаат ундны усаар хангах;
- Гэр хорооллыг орон сууцны анхан шатны дэд бүтэц буюу цэвэр, бохир усны шугам сүлжээнд холбож иргэдийг амины орон сууцтай болгох;
- Инженерийн шугам шүлжээтэй орон сууцанд амьдарч байгаа хүн амын тоог өсгөх;

Хоёрдугаар үе шат (2016-2021 он):

Стратегийн зорилт 1. Хүн амын өсөлт, орон сууцны хэрэгцээтэй уялдуулан иргэдийн орон сууцны хангамжийн түвшинг эрс дээшлүүлнэ:

- Аймгийн төв, сумдын бага орлоготой болон залуу гэр бүлийг орон сууцаар хангах дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх;
- Төрийн албан хаагчдад зориулсан орон сууцны хоёр дахь шатны төсөл боловсруулан хэрэгжүүлэх;
- Орон гэргүй байгаа ядуучуудыг орон байраар хангах цогц арга хэмжээ авах;
- Эдийн засаг, худалдааны чөлөөт бүсүүд, томоохон орд газрыг түшиглэн дэлхийн жишигт нийцсэн орчин үеийн хот, сууринг бий болгох;
- Барилгын материалын үйлдвэрлэлд шинэ техник, технологийг нэвтрүүлж, бүтээгдэхүүний чанарыг сайжруулж, нэр төрлийг нь олшруулах;
- Хувийн орон сууц барихыг бүх талаар дэмжих;
- Орон сууц барихад улсын болон хувийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх;

ТАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ БОДЛОГО

Үндэслэл: Говь-Алтай аймагт дэлхийд ховордож улаан номонд орсон мазаалай, ирвэс, хулан, тахь, хавтгай, аргаль, янгир ямаа, хар сүүлт, цоохондой, зэгсний гахай, соотон алаг даага, зэрэг амьтад, 3 төрлийн тогоруу,

2 төрлийн галуу, 2 төрлийн жороо тоодог, цахлай, хотон өрөвтас, сар, цагаан сувлт бvргэд, гургуул зэрэг шувууд бий бөгөөд сүүлийн үед тоо толгой нь улам цөөрсөөр байна. Мөн вансэмбэрүү, гоёо, зээрийн ундаа, хулангийн ундаа, эрээн гомбо, үүргэнэ, юмдүүжин, алтан гагнуур, чихэр өвс, зээргэнэ, гандигар, хурдан цагаан, лидэр, тарваган шийр, дэгд, таван салаа, минжиннавга, газрын үс зэрэг эмийн болон суль, сульхир, сонгино, хармаг, нохойн хошуу, тошлой зэрэг хүнсний ургамал бий. Ашигт малтмалын нөөцийг ашиглаж эхлэх бэлтгэл ажлууд хийгдэж байна. Аймаг нийт нутаг дэвсгэрийнхээ 86 хувь буюу 12,2 сая га газрыг бэлчээрийн зориулалтаар ашиглаж байгаа боловч ихэнх сумдад малын тоо толгойн өсөлттэй уялдан бэлчээрийн даац хэтэрсэний зэрэгцээ үлийн цагаан оготно, царцаа, дэвхрэг 591,0 га талбайд тархсан нь цөлжилтөд нөлөөлөх болов. Аймгийн нутгийн 60 шахам хувь нь байгалийн хүчин зүйл болон хүний зүй бус үйл ажиллагааны нөлөөгөөр цөлжилтийн байдалд ороод байна. Ялангуяа Хөх морьт, Ургамал зэрэг сумд шаваг, харгана зэргийг зүй бусаар ашигласны улмаас сумын төв элсэнд дарагдаж, Монгол элс, Бөөрөг дэл зэрэг томоохон элстэй нутгийн элсний нүүдэл ихсэх хандлагатай байна.

Аймгийн хэмжээнд 1010 орчим булаг, шанд, гол горхи, рашаан тоологдсоноос цөлжилт болон хүний зүй бус үйлдлийн улмаас ширгэх, бохирдох нь ихсэж байна. Агаар бохирдуулагч эх үүсвэрийн тооллогоор аймгийн хэмжээнд 6463 суурин эх үүсвэр, 3000 гаруй хөдөлгөөнт эх үүсвэр байгаа нь тогтоогджээ. Иймд Говь-Алтай аймагт байгаль орчныг хамгаалах, нөөц баялагийг зохистой ашиглах, хяналтыг чангатгах нь онцгой ач холбогдолтой болж байна.

Бүх үе шат (2008-2021 он):

Стратегийн зорилт 1. Байгаль орчны бохирдол, доройтлыг бууруулна:

- Аймгийн байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх талаар 2010 он хүртэл хэрэгжүүлэх мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх;
- Аймаг сумдын байгаль орчны мэдээлэлийн сангийн бүрдүүлэлтийг иж бүрнээр хийж, байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг ашиглах шийдвэр гаргах зэрэгт үндсэн хэрэглэгдэхүүн болгож занших;
- Байгаль орчинд учруулсан хохирлын эдийн засгийн үнэлгээнд тулгуурлан нөхөн сэргээх бодлогыг хэрэгжүүлэх;

- Сэргээгдэх эрчим хүч ашиглах хувь хэмжээг нэмэгдүүлж, нар, салхи, усны эрчим хүчний эх үүсвэрийн дан болон хоршсон хэрэглээг хөгжүүлэх;
- Айл өрх, албан байгууллагын хашаа, эзэмшил газар, нийтийн эзэмшлийн газруудыг цэцэрлэгжүүлэх, зүлэгжүүлэх ажлыг бүх нийтийн хөдөлгөөн болгон өрнүүлэх;
- Хот, суурин газрын хатуу хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, хадгалах, ялган ангилах, дахин боловсруулах, эргүүлж ашиглах, байгальд халгүй аргаар устгахад шинэ технологи, менежментийн цогц бодлого хэрэгжүүлэх;
- Байгаль орчныг хамгаалах чиглэлээр иргэд, нөхөрлөл, төрийн бус байгууллагуудтай хамтран, тэдгээрийн санал, үйл ажиллагааг дэмжиж ажиллах;

Стратегийн зорилт 2. Газар ашиглалтын оновчтой тогтолцоог бүрдүүлнэ:

- Газар ашиглалтын төлөв байдал, үржил шимийг дээшлүүлэх, түүнчлэн стандартын холбогдолтой мэдээ, мэдээллийг иргэдэд хүргэх оновчтой тогтолцоог бий болгох;
- Газрын нөөцийн менежментийг сайжруулж, газар зохион байгуулалтын орчин үеийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах;
- Уул уурхайн үйлдвэрлэл ялангуяа алтны хайгуулын болон ашиглалтын замбараагүй үйл ажиллагааны уршгаар бий болсон хохирол гажуудлыг арилгуулахад нутгийн өөрөө удирдах ёсны болон нутгийн захиргааны байгууллага, иргэний нийгмийн байгууллагын хүчийг нэгтгэн зохион байгуулах;
- Химийн хорт бодисоор бохирдсон газар нутгийн хөрс, усыг хоргүйжүүлэх арга хэмжээ авах;
- Байгалийн үзэсгэлэнт болон түүх соёлын дурсгалт газар нэн ховор, ховордсон ан амьтан, ургамалтай бүс нутгийг аймгийн тусгай хэрэгцээ, хамгаалалтанд авах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх;
- Тариалангийн эргэлтээс хасагдаж байгаа талбайн хөрсний эвдрэлийг зогсоож, олон наст ургамлын үр тарих, бэлчээрийн нөөцөд шилжүүлэх арга хэмжээ авах;
- Хөрсийг элэгдэл, эвдрэлээс хамгаалж, тариалангийн талбайг тойруулж ойн зурвас тарьж ургуулах, таримал болон тэжээлийн, эмийн ургамал тариалах замаар ашиглах;

Стратегийн зорилт 3. Усны нөөцийг бохирдол, хомсдолоос хамгаалаж, зохистой ашиглан хүн амыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн усаар хангана:

- Төв, суурингийн усны бохирдлыг бууруулах арга хэмжээг тодорхой төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх;
- Хүн амын ундны усыг зөөлрүүлэх, цэнгэгжүүлэх бага оврын тоног төхөөрөмжийг сумдад суурилуулж, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн усны хэрэглээг нэмэгдүүлэх;
- Экологийн тэнцвэрт байдалд сөрөг нөлөөгүй услалтын системүүдийг газар тариаланд ашиглах;
- Жил бүр 60-аас доошгүй уст цэгт засвар шинэчлэлтийг үргэлжлүүлэн хийж, бэлчээр усжуулалтын түвшинг 50-аас доошгүй хувьд хүргэх;
- Хурын усыг хуримтлуулж хөв, цөөрөм байгуулах;
- Усны нөөцийг зохистой ашиглах хамгаалах, чиглэлээр олон нийтийг хамарсан сурталчилгааг зохион байгуулах;
- Хамгаалалт барьж тохижуулсан усны эх үүсвэр, булаг шандын эхийн тоог нэмэгдүүлэх;

Стратегийн зорилт 4. Ойн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, ажлыг сайжруулан экологийн тэнцвэрт байдлыг нь хадгална:

- Аймгийн ойн нөөцийг сум, багийн нутаг дэвсгэрийн хэмжээнд шинэчлэн тогтоож, экологи-эдийн засгийн үнэлгээ хийлгэн нөхөн сэргээх, ашиглах, хамгаалах төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх;
- Ойг хамгаалах, ашиглах, нөхөн сэргээх ажлыг мэргэжлийн боловсон хүчин, тоног төхөөрөмжөөр хангах;
- Жил бүр нийтээр мод тарих өдөртэй болж, хот суурин газрыг цэцэрлэгжүүлэх, гол усны эх, тариалангийн талбай, авто замын дагуу ойн зурвас байгуулах;
- Ойн нөхөн сэргээлтийн ажлыг эдийн засгийн хөшүүрэг хэрэглэн урамшуулж, энэ талын сургалт, сурталчилгааны ажлыг сайжруулах;
- Заг болон говийн бутлаг ургамлыг үрээр тариалж буй иргэд, аж ахуйн нэгжүүдийн санаачилгыг дэмжих;
- Шарга, Халиун сумдад заган ойн үржүүлгийн газар байгуулах;
- Аймгийн заган болон шинэсэн ойн нөөцийн судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, цаашид энэ ажлыг тогтмолжуулах;

- “Ногоон хэрэм” үндэсний хөтөлбөрийн хүрээнд жил бүр 30-аас доошгүй га талбайд ойн зурвас байгуулах;
- Улс, орон нутгийн төсөв болон аж ахуйн нэгж байгууллагын хөрөнгөөр жил бүр 80-аас доошгүй га талбайд ойжуулалт хийх;
- Газрын генератор ашиглан цаг агаарт зориудаар нөлөөлж хур тундасыг нэмэгдүүлэх;

Стратегийн зорилт 5. Амьтан, ургамлын нөөцийг хамгаалж, тэдгээрийн байгалийн жамаар нөхөн сэргэх нөхцлийг бүрдүүлнэ:

- Аймгийн биологийн төрөл зүйлийг хамгаалах хөтөлбөр хэрэгжүүлэх;
- Байгаль орчныг хамгаалах үндэсний уламжлалт аргуудыг өргөн хэрэглэх;
- Байгалийг хайрлан хамгаалах хүмүүжлийг хүүхэд, залуучуудад төлөвшүүлэх ажлыг эрчимжүүлэх;
- Нэн ховор, устах аюул нүүрлэж буй амьтан, ургамлыг эхний ээлжинд хамгаалах, нөхөн сэргээх;
- Тусгай хамгаалалттай газар нутгийн экосистемийн горим, зүй тогтлыг танин мэдэх, байгалийн нөөц, баялгийг үнэлж тодорхойлох, зохистой ашиглах, хамгаалах;
- Дархан цаазат газар болон байгалийн цогцолбор газрын орчны бүсүүдэд байгаль орчинд халгүй аж төрөх хөгжлийн төслүүдийг хэрэгжүүлж эхлэх;
- Ховор, нэн ховор амьтан ургамлыг сэргээн нутагшуулах, тарималжуулах, зориудын аргаар үржүүлэх, генийн санг хамгаалах тогтолцоог бүрдүүлж, гадаад орон, олон улсын байгууллагын төсөл хөтөлбөрт хамруулах;
- Шарга-Манханы байгалийн нөөц газарт “Монгол бөхөн” хамгаалах төслийг хэрэгжүүлэх;
- Агнуурын эдэлбэр нутагт ан амьтдад зориулан өвс тэжээл бэлтгэх, булаг шанд задгайлах, тэжээлийн ургамал тариалах, үүр ноохой бэлдэх, долооц тавих, мараа ургуулах зэрэг биотехникийн арга хэмжээ авч хэрэгжүүлэн, эдэлбэр нутгийн ашиглалт хамгаалалтыг сайжруулах;
- Байгаль хамгаалагчдыг шаардлагатай техник хэрэгслээр бүрэн ханган, ТХГН-ийн хамгаалалтын захиргааны байгаль хамгаалагчид, сумдын байгаль хамгаалагчдыг сүлжээнд холбох;
- Байгаль хамгаалах чиглэлээр олон улсын байгууллага, гадаад төсөл, хөтөлбөрүүдтэй өргөн хамтран ажиллах;

Стратегийн зорилт 6. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, цөлжилтийг сааруулах, сөрөг үр дагаврыг бууруулах чадавхийг бүрдүүлнэ:

- Уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны төлөв байдал, байгалийн гамшгийн мэдээллийн төвийг байгуулан ажиллуулах;
- Байгаль орчны мэргэжлийн хяналтын лабораторуудыг орчин үеийн техник хэрэгслэлээр бэхжүүлж, мэргэжилтнүүдэд оношлогоо шинжилгээний орчин үеийн мэдлэг эзэмшүүлэх;
- Байгаль цаг уурын гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, техникийн хүчин чадлыг бий болгох;
- Аймгийн хэмжээнд цөлжилттэй тэмцэх хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж цөлжилтийн хамрах хүрээг багасгах;
- Цөлжилтөд илүүтэй нэрвэгдсэн Хөхморьт сумын төвийн эргэн тойронд болон Монгол элсний өвөр хэсгээр ногоон төгөл байгуулах;
- Элсний нүүдлийг зогсоох, говийн ургамалжилтыг нөхөн сэргээхэд ашиглаж болох ургамлуудыг (заг, жигд, хайлаас, харгана, бүйлс, хотир гэх мэт) тодорхой үе шаттайгаар сонгон тариалах;
- Бигэрийн Өөш, Мянгайн гол, Дагналтайн услалтын системийг түшиглэн элсний нүүдлийг сааруулах зорилгоор ойн зурвас байгуулах, мөн орон нутгийн түлшний хэрэгцээг хангах зориулалт бүхий саваа мод үржүүлгийн аж ахуй байгуулах;
- Мал ихээр бөөгнөрч бэлчээр талхлагдахаас урьдчилан сэргийлэх;
- Сул хөрсийг тогтоох, ургамалжуулах талаар гадаад орнуудын дэвшилтэт технологийг судалж нэвтрүүлэх;
- Цөлжилтэй тэмцэх ажилд нутгийн санаачилгатай иргэд болон ажилгүй иргэдийн оролцоог нэмэгдүүлэх;
- Орон нутгийн түлшний хэрэгцээг үйлдвэрлэлийн аргаар хангах;

ЗУРГАА. ХҮРЭХ ГОЛ ҮР ДҮН, ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ МЕХАНИЗМ

6.1. Цогц бодлогыг хэрэгжүүлснээр хүрэх гол үр дүн

Говь-Алтай аймгийн хөгжлийн цогц бодлогыг хэрэгжүүлснээр дараахь томоохон үр дүнд хүрнэ:

I үе шат (2008-2015 он)-ны эцэст бизнесийн үйл ажиллагаа идэвхжиж, эдийн засгийн өндөр өсөлтийг хангах нөхцөл бүрдэхийн зэрэгцээ экспортын үйлдвэрлэл, үйлчилгээ өргөжиж, эдийн засгийн бүтцэд аж үйлдвэрийн эзлэх байр суурь сайжирч, эрдэс баялгийн үйлдвэрүүд байгуулагдан, ДНБ-ий жилийн дундаж өсөлт 20 хувиас доошгүй өснө. Ноос боловсруулах үйлдвэр байгуулагдан оёмол, нэхмэл, сүлжмэл бүтээгдэхүүний үйлдвэрлэл бий болно. Ямааны ноолуурын үйлдвэр, арьс шир боловсруулах үйлдвэр, мах боловсруулах бага, дунд оврын үйлдвэр, сүү боловсруулах бага, дунд оврын үйлдвэр тус тус байгуулагдан ажиллаж эхлэнэ. Орчин үеийн технологиор хүнсний ногоо, жимс жимсгэнийг савлаж борлуулах үйлдвэрлэл бий болно. Өндөр технологи хэрэглэн аймагт түгээмэл тархсан барилгын материалын түүхий эдийг боловсруулж цемент, барилгын бетон хийцүүд, тоосго, эрдэс будаг зэрэг бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ. Чацаргана, улаан хальст сармис, арвай боловсруулах үйлдвэрүүд байгуулагдана. Аялал жуулчлалыг дагасан үйлдвэрлэл, үйлчилгээ бүх чиглэлээр хөгжинө. Ингэснээр эдийн засгийн салбарын бүтцэд ихээхэн эерэг өөрчлөлт орж ДНБ-ний 26 хувийг аж үйлдвэр барилгын салбарт, 36 хувийг ХАА-н салбарт, 38 хувийг үйлчилгээний салбарт тус тус үйлдвэрлэнэ. Мөн аж үйлдвэрийн салбарын ДНБ-ий 54 гаруй хувийг боловсруулах салбарт үйлдвэрлэж, экспортын баримжаатай боловсруулах үйлдвэрлэл бий болно. Геологи, уул уурхай, эрдэс баялаг, хүнд үйлдвэрийн салбарын ДНБ энэ үе шатанд жилд дундажаар 9 хувиар өсч, аж үйлдвэрийн салбарын ДНБ-ий 42 хувийг үйлдвэрлэх болно. Бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг хослуулан хөгжүүлж, малын үүлдэрлэг чанарыг сайжруулан, газар тариаланг хөгжүүлснээр ХАА-н салбарын үйлдвэрлэл энэ үе шатанд жилд дундажаар 10 хувиар өснө. Мөн аймгийн хэмжээнд ядуурлыг 2 дахин бууруулж, ажилгүйдлийн түвшинг 2 хувиас дээшгүй байлгаж, ЕБС-ийг 12 жилийн тогтолцоонд бүрэн шилжүүлж, дотуур байранд суух хүүхдийн тоог 2 дахин нэмэгдүүлнэ. Мөн 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл болон нялхсын

эндэгдлийн түвшинг 1000 амьд төрөлт тутамд 25.8-аас цөөн болгож бууруулна.

II үе шат (2016-2021 он)-ны эцэст эдийн засгийн бүтэц ихээхэн сайжирч, дэвшилтэт техник, технологи, менежмент бүхий үйлдвэрлэл, үйлчилгээ өсөн мэдлэгт суурилсан эдийн засаг бий болно. Уул уурхайн болон боловсруулах салбарын үйлдвэрүүдийн үйл ажиллагаа жигдрэнэ. Эдийн засаг энэ үе шатанд жилд дундажаар 17 хувиас доошгүй өсөж, аймгийн ДНБ-ий 37 хувийг аж үйлдвэр барилгын салбарт, 43 хувийг орчин үеийн үйлчилгээний салбарт тус тус үйлдвэрлэнэ. Бургастайн боомтыг түшиглэн худалдааны чөлөөт бүс бий болно. Цогц бодлогыг хэрэгжүүлснээр Говь-Алтай аймаг хоцрогдлыг харьцангуй богино хугацаанд даван туулж, аймгийн хүн ам төрж өссөн нутагтаа ая тухтай ажиллаж, амьдрах таатай орчин бүрдэх болно.

6.2. Цогц бодлогын хэрэгжилтийг хангах механизм

Говь-Алтай аймгийн хөгжлийн цогц бодлогыг аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэрүүд болон энэ баримт бичгийн хүрээнд боловсруулах дэд хөтөлбөр, мастер төлөвлөгөө, төслүүдэд тусган хэрэгжүүлнэ. Аймгийн цогц бодлогод тулгуурлан сум бүр хөгжлийн мастер төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ. Аймгийн цогц бодлогыг хэрэгжүүлэхдээ Швейцарийн Холбооны Улсын Юра муж, БНХАУ-ын ШУӨЗО-ны Хами аймаг, Ганьсу муж зэрэг гадаад түншүүдтэй тогтоосон хамтын ажиллагаагаа өргөн ашиглана.

Говь-Алтай аймгийн хөгжлийн цогц бодлогын жил бүрийн хэрэгжилтийг Засаг дарга дараа жилийн эхний улиралд багтаан Иргэдийн төлөөлөгчдийн хуралд тайлагнана.

Говь-Алтай аймгийн хөгжлийн цогц бодлогод тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны явцад цогц бодлогод тусгагдсан хүрэх түвшингийн үзүүлэлтүүдийг ашиглан хяналт, шинжилгээ хийж, ахиц дэвшил, үйл ажиллагааны үр дагаврыг үнэлэн дүгнэх ажлыг дараахь байдлаар зохион байгуулна:

Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтын хэрэгжилтийн явцад хяналт шинжилгээ хийх, үр дүнг үнэлэн дүгнэх үе шатууд:

I үе шат: Бодлогын зорилтын эхний шатны үнэлгээ хийх (Хугацаа: 2011 оны 6 дугаар сар);

II үе шат: Бодлогын зорилтын дунд шатны үнэлгээ хийх (Хугацаа: 2015 оны 6 дугаар сар);

III үе шат: Бодлогын зорилтын эцсийн шатны үнэлгээ хийх (Хугацаа: 2020 оны 6 дугаар сар).

Хяналт, шинжилгээ, үнэлгээг аймгийн төрийн захиргааны төв байгууллага холбогдох мэргэжлийн болон судалгааны, түүнчлэн төрийн бус байгууллагуудын оролцоотойгоор хийх бөгөөд зохих зардлыг төсөвт тусган санхүүжүүлнэ.

_____о О о_____